



САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 IX сар

№17

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 оны 9 дүгээр сар

АГУУЛГА

ХУРААНГУЙ	5
1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	9
1.1 Дэлхийн эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал	9
Шигтгээ 1. Хятадын үл хөдлөхийн салбарын хүндрэл даамжирч, эдийн засгийн өсөлтийн төлөв муудлаа	12
1.2 Дэлхийн санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал	13
Шигтгээ 2. АНУ, Европын банкны салбарын хүндрэл дэлхийн санхүүгийн салбарыг доргиов	15
2. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	16
2.1 Төлбөрийн тэнцэл	16
2.2 Өрх, иргэд	18
2.3 Аж ахуйн нэгж	22
2.4 Улсын төсөв	26
Шигтгээ 3. Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал	28
3. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	30
3.1 Банкны салбарын нөхцөл байдал	30
Шигтгээ 4. Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн	33
3.2 Банкны салбарын эрсдэлийн шинжилгээ	35
Шигтгээ 5. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа	38
3.3 Банкны бус санхүүгийн салбарын нөхцөл байдал	40
3.4 Банкны бус санхүүгийн салбарын эрсдэлийн шинжилгээ	47
4. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН	50
4.1 Банкны салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	50
Шигтгээ 6. Санхүүгийн мөчлөг	54
4.2 Банкны бус санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	55

ХУРААНГУЙ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 17 дахь дугаарыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран боловсруулж, олон нийтэд хүргэж байна. Уг тайлан нь 1) Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал; 2) Дотоод эдийн засгийн орчин; 3) Санхүүгийн салбар, түүний эрсдэл, эмзэг байдал; 4) Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ гэсэн нийт 4 бүлгээс бүрдэнэ.

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал

Геополитикийн хурцадмал байдал, өндөр инфляц, хүүгийн өсөлтөөс үүдэн эдийн засгийн идэвхжил саарч, дэлхийн эдийн засгийн өсөлт 2022 онд 3.5 хувьд хүрч буурахад хүргэв. Түүнчлэн, дэлхийн зарим томоохон орнууд мөнгөний бодлогын төлөвөө үргэлжлүүлэн чангаруулахын зэрэгцээ геополитикийн асуудлаас үүдэлтэй тодорхой бус байдал өндөр хэвээр байна. БНХАУ-ын эдийн засгийн зарим голлох үзүүлэлтүүд 2023 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр хүлээлтээс доогуур гарч, тус улс эдийн засгийн томоохон хүндрэлтэй тулгарч болзошгүй гэсэн болгоомжлолыг бий болгоод байна. БНХАУ-ын эдийн засагт томоохон хүндрэл тулгарч, эдийн засгийн идэвхжил улам бүр саарвал худалдаа, эдийн засгийн түнш орнуудад ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй.

Инфляцын эрч 2022 оны дунд үеэс эхлэн улс орнуудын хувьд саарч байгаа хэдий ч суурь инфляц ихэнх төв банкны зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Нэг талаас дэлхийн улс орнууд дахь инфляцын өндөр түвшин нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтэд сөргөөр нөлөөлж байгаа бол нөгөө талаас Холбооны нөөцийн банк тэргүүтэй зарим томоохон төв банкууд инфляцын эсрэг мөнгөний хатуу

бодлого үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа нь банкуудын зээлийн нөхцөл чангарах, санхүүжилтийн зардал нэмэгдэх, зээлийн нийлүүлэлт хумигдах, улмаар эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах нөлөөтэй.

Дэлхийн зарим томоохон орнууд мөнгөний бодлогын төлөвөө үргэлжлүүлэн чангаруулж байгаа болон БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байгаа нь дэлхийн аж үйлдвэрлэлийг сааруулж, улмаар үйлдвэрлэлийн голлох орц эрдэс бүтээгдэхүүнүүдийн эрэлт, үнэ буурч байна. Дэлхийн аж үйлдвэрлэл үргэлжлэн саарч, эрдэс түүхий эдийн үнийн бууралт цаашид үргэлжилбэл түүхий эд экспортлогч орнуудад ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

Хөгжингүй орнуудад санхүүгийн нөхцөл аажим суларч, хөрөнгийн зах зээлийн сэргэлт бүс нутгуудад харилцан адилгүй байна. Тухайлбал, дэлхийн хоёр том эдийн засгийн нэг болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээл ганхаж байгаа нь дэлхийн санхүүгийн зах зээлд сөргөөр нөлөөлж, Хонгконгийн хөрөнгийн захын Hang Seng индекс 2023 оны 8 дугаар сард энэ оны эхэн үе дэх оргил түвшнээсээ 21 хувиар огцом сулав.

Хөгжиж буй орнуудын засгийн газрын өр хурдацтай нэмэгдэж, цаашид үргэлжлэн өсөх төлөвтэй байгаагийн зэрэгцээ геополитикийн зөрчилдөөнөөс үүдэн дэлхийн санхүүгийн нэгдмэл байдал алдагдаж байгаа нь санхүүгийн тогтвортой байдалд тодорхой эрсдэл учруулж байна.

Дотоод эдийн засгийн орчин

БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдсэнээс хойш экспорт эрчимтэй өсөж, манай улсын урсгал тэнцэл сайжирлаа. Ялангуяа нүүрсний экспортын биет хэмжээ

түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь урсгал тэнцэл эерэг гарах гол хүчин зүйл байв. Хөрөнгө санхүүгийн данс 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар буурсан хэдий ч урсгал тэнцэл сүүлийн 2 улирал дараалан ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөллөө. Улмаар төлбөрийн тэнцэл 2023 оны эхний хагаст 473.8 сая ам.долларын ашигтай гарав. Ийнхүү төлбөрийн тэнцэл сайжирсан нь төгрөгийн ханш сулрах дарамтыг бууруулж, гадаад валютын албан нөөц (ГВАН) өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өсөж, 2023 оны 6 дугаар сарын эцэст 3817.8 сая ам.долларт хүрэв.

Хөдөлмөрийн захын голлох үзүүлэлтүүд сайжирч цар тахлын өмнөх түвшинд ойртож, бодит цалин сүүлийн 4 улирал дараалан өсөв. Цалин хөлсний өсөлтийн нөлөөгөөр өрхийн дундаж орлого нэмэгдэж байгаа хэдий ч, өрхийн зарлага орлогоос илүү хурдтай тэлж байна. Өрхийн орлого зарлагын зөрүү үргэлжлэн өсөж, зөрүүг зээлээр санхүүжүүлэх тохиолдолд өрхийн өр нэмэгдэж, өрийн дарамтад орох эрсдэлтэй.

2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудаас олгосон иргэдийн зээлийн үлдэгдэл 20.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар өсөв. Иргэдийн зээлийн өсөлтийн гол хэсгийг хэрэглээний зээл болон ипотекийн зээлийн өсөлт бүрдүүлж байна. Нөгөөтэйгүүр, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон иргэдийн зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдлээ. Тодруулбал, 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ББСБ-ын иргэдийн зээлийн үлдэгдэл 2.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар, 2018 оны эцсээс 3.8 дахин нэмэгджээ.

2023 оны 2 дугаар улиралд эдийн засгийн сэргэлтийг даган үйл ажиллагаа явуулж

буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэн боловч, үйл ажиллагаа бүрэн зогсоосон аж ахуйн нэгжүүдийн тоо мөн өсөв. Эдийн засгийн сэргэлтийг даган уул уурхай болон уул уурхайгаас хамаарал бүхий тээвэр, худалдааны салбарын борлуулалтын орлого нэмэгдлээ.

Банкны салбар дахь хувийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 11.2 их наяд төгрөгт хүрлээ. Үүний 32.0 хувийг худалдаа, 16.3 хувийг барилга, 15.7 хувийг боловсруулах, 11.2 хувийг уул уурхай, 24.8 хувийг бусад салбарын зээл тус тус бүрдүүлж байна. Гэвч аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл нь салбараар болон зээлдэгчийн хувьд төвлөрөл өндөр хэвээр байна.

Эдийн засгийн зарим салбаруудын сэргэлтээс шалтгаалан төсвийн тэнцэл сайжирч байна. Тухайлбал, уул уурхайн салбарын өсөлтийг даган аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом нэмэгдээд байгаа нь төсвийн орлого бүрдүүлэлт цаашлаад төсвийн тэнцэлд эергээр нөлөөлж байна. Монгол Улсын нийт гадаад өр 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 33.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өссөн нь гадаад өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна.

Санхүүгийн салбарын төлөв байдал

Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 их наяд төгрөгөөр өсөж, 25.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг иргэдийн зээлийн өсөлт бүрдүүлэв. Харин банкны системийн активын жилийн өсөлтийг мөнгөн хөрөнгө болон Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт голлон бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй

харьцуулахад зээлийн нийт активт эзлэх хувь буурч, бизнесийн зээлийн өсөлт саарч байна.

Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүдээс харахад 2023 оны 6 дугаар сарын байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байв. Түүнчлэн, 2023 оны эхний хагас жилд банкны салбар 606.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, улмаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж нэмэгдэв.

Банкууд IPO хийсэн нь хөрөнгийн зах зээлийн идэвхжилийг нэмэгдүүллээ. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өсөж, 2022 оны нэрлэсэн ДНБ-ий 20.8 хувьтай тэнцэж байгаа бол нийт арилжаалагдсан үнэт цаасны дүн өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өслөө.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2023 оны эхний хагас жилийн байдлаар байдлаар 518.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар өссөн бол нөөц сангийн хэмжээ 244.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар нэмэгдээд байна. Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 53.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тодруулбал, нийт хөрөнгө 2023 оны 2 дугаар улиралд 3.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар, нийт зээлийн хэмжээ 3.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар тус тус өслөө.

Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монголбанк банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлүүлэн хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн томоохон зорилтуудын нэг болох банкны хяналт, шалгалтын стандартыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Тухайлбал, системд нөлөө бүхий банкуудад активын чанарын үнэлгээг гүйцэтгэж, “Банкыг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”, “Банкыг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн авагч томилох, дуусгавар болгох журам”, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүү бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах журам” зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлууллаа.

Түүнчлэн, Монголбанкнаас санхүүгийн системийн мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд өр орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалт тогтоох макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн банкуудын гадаад зах зээлээс шинээр татсан зарим эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэр гаргав.

Банк бус санхүүгийн салбарын зохицуулалтын орчныг холбогдох хууль, цаг үеийн хөгжлийн чиг хандлага болон олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос холбогдох хууль, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчны хүрээнд “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг шинэчлэв. Түүнчлэн, даатгалын салбарын гол хуулиуд болох Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудыг илүү боловсронгуй болгохоор ажиллаж байна.

ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор ББСБ-уудын тусгай зөвшөөрөл авах шаардлагыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд СЗХ-ноос “Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн

байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарь”-ийг батлав.


Монгол Улсад виртуал хөрөнгийн зах зээл эрчимтэй хөгжиж байгаа тул виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчид учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам болон бусад холбогдох төрийн байгууллагуудын хамтран ажиллаж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас баталсан бөгөөд тус хуулийн дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 10 харилцааг зохицуулсан 8 журмыг батлан, үйл ажиллагаанд мөрдүүлж байна.

1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Дэлхийн зарим томоохон орнууд мөнгөний бодлогын төлөвөө үргэлжлүүлэн чангаруулж буйн зэрэгцээ геополитикийн асуудлаас үүдэлтэй тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд сөргөөр нөлөөлж байна. 2022 онд бий болсон геополитикийн хурцадмал байдал, өндөр инфляц, хүүгийн өсөлтөөс үүдэн эдийн засгийн идэвхжил саарч, 2022 онд дэлхийн эдийн засаг 3.5 хувиар өсөв. Улмаар Олон улсын валютын сан (ОУВС)-гийн шинжээчид 2023 оны 4 дүгээр сард 2023 болон 2024 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг түүхэн дунджаас¹ бага түвшинд буюу харгалзан 2.8 болон 3 хувь байна хэмээн таамаглаад байв.

Зураг 1.1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Тэмдэглэл: Төсөөлөл хийсэн хугацааг саарал суурь өнгөөр тодотгов.


Харин хөгжиж буй орнуудын эдийн засагт гарч буй зарим эерэг өөрчлөлтийг харгалзан 2023 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид

¹ Дэлхийн эдийн засаг 2000-2019 онд дунджаар 3.8 хувийн өсөлттэй байсан.

энэ оны эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар нэмэгдүүлж, 3.0 хувь байхаар шинэчлэн тооцов. Мөн Евро бүс, АНУ-ын өсөлтийн төсөөллийг 0.1, 0.2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, 0.9, 1.8 хувь болгосон бол БНХАУ-ын өсөлтийн төсөөллийг 5.2 хувьд хэвээр хадгаллаа (Зураг 1.1). Гэвч БНХАУ-ын эдийн засгийн моментум муудаж байгаатай холбоотойгоор өсөлтийн төсөөллийг бууруулж болзошгүй юм.

2023 оны эхний улиралд дэлхийн эдийн засгийн идэвхжил харьцангуй өндөр байсан ба үүнд үйлчилгээний салбарын сэргэлт голлон нөлөөлөв. Гэвч 2022 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулсан суурь хүчин зүйлсийн нөлөөлөл энэ онд үргэлжилсэн хэвээр байна.

Зураг 1.2. Зарим орнуудын бодлогын хүүгийн динамик



Эх сурвалж: Блүүмберг.


Тодруулбал, нэг талаас дэлхийн улс орнууд дахь инфляцын өндөр түвшин нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлтэд сөргөөр нөлөөлж байгаа бол нөгөө талаас Холбооны

нөөцийн банк тэргүүтэй зарим томоохон төв банкууд инфляцын эсрэг мөнгөний хатуу бодлого үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа нь банкуудын зээлийн нөхцөл чангарах, санхүүжилтийн зардал нэмэгдэх, зээлийн нийлүүлэлт хумигдах, улмаар эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах нөлөөтэй (Зураг 1.2).

БНХАУ-ын эдийн засгийн зарим голлох үзүүлэлтүүд 2023 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр хүлээлтээс доогуур гарч, тус улс эдийн засгийн томоохон хүндрэлтэй тулгарч болзошгүй байна. БНХАУ-ын эдийн засгийн 20 гаруй хувийг бүрдүүлдэг, эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болсон үл хөдлөх хөрөнгийн салбарт томоохон хүндрэл үүсээд байна. Тодруулбал, БНХАУ-ын хамгийн том үл хөдлөх хөрөнгийн компаниудын нэг болох Country Garden-д өрийн хямрал нүүрлэж, бондын эргэн төлөлтөө төлж чадахгүйд хүрсэн нь хөрөнгө оруулагчдын итгэл, эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөв. БНХАУ-ын Үндэсний Статистикийн Товчооноос зарласнаар 2023 оны 7 дугаар сард тус улсын жижиглэн худалдаа, аж үйлдвэрлэл болон хөрөнгө оруулалтын өсөлт хүлээлтээс доогуур гараад байна. Түүнчлэн, БНХАУ-ын залуучуудын ажилгүйдлийн түвшин 2023 оны 6 дугаар сард 21.3 хувь буюу түүхэн дээд түвшиндээ хүрээд байсан бөгөөд БНХАУ уг үзүүлэлтийг олон нийтэд мэдээллэхээ зогсоосон нь эргэлзээ дагуулж байна. Олон улсын шинжээчдийн сүүлийн үеийн таамаглалаар БНХАУ-ын ДНБ-ийн өсөлт 2023 оны зорилтот түвшин болох 5 хувьд хүрч чадахааргүй байна. Ийнхүү БНХАУ-ын эдийн засагт томоохон хүндрэл тулгарч, эдийн засгийн идэвхжил улам бүр саарах эрсдэлтэй байгаа нь эдийн засаг, худалдааны түнш орнуудад ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

Олон улсын хэмжээнд инфляцын эрч саарч байгаа хэдий ч суурь инфляц² ихэнх төв банкны зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Дэлхий даяар инфляцын түвшин 2022 оны дунд үеэс буурч эхэллээ. Инфляцыг бууруулж буй гол хүчин зүйл нь улс орнуудын төв банкууд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байгаагаас гадна олон улсын зах зээлд түүхий эдийн үнэ буурч буй явдал юм. Тухайлбал, Европт байгалийн хийн нөөц нэмэгдэж, нийлүүлэлт тогтворжсоноос шалтгаалан АНУ, Евро бүсэд шатахуун, эрчим хүчний үнэ буурлаа. Гэсэн хэдий ч суурь инфляц хүлээлтээс удаан буурч, ихэнх төв банкны зорилтот түвшнээс харьцангуй өндөр хэвээр байна.

Зураг 1.3. Инфляцын түвшин, төсөөлөл



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Тэмдэглэл: Төсөөлөл хийсэн хугацааг саарал суурь өнгөөр тодотгов.

2023 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид дэлхийн инфляцын төсөөллийг 2023 онд 6.8 хувь, 2024 онд 5.2 хувь байхаар тооцоод байна (Зураг 1.3).

² Суурь инфляцыг хүнсний болон эрчим хүчний үнийг хасаж тооцсон.

Дэлхийн аж үйлдвэрлэл саарснаар үйлдвэрлэлийн голлох орц эрдэс бүтээгдэхүүнүүдийн эрэлт, үнэ буурч байна.

Дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлт 2021 оны сүүлийн хагасаас эхлэн эрчимтэй буурч, 2023 оны 5 дугаар сарын байдлаар 1.0 нэгж хувьд хүрлээ. Улс орнуудын төв банкууд инфляцын эсрэг хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого, БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байгаа нь ийнхүү дэлхийн аж үйлдвэрлэл саарах үндсэн шалтгаан болж байна (Зураг 1.4). Улмаар дэлхийн аж үйлдвэрлэлийн сааралт нь аж үйлдвэрлэлийн орц түүхий эдүүдийн эрэлтийг бууруулж, үнийг бууруулах нөлөөтэй байна. Тухайлбал, дэлхийн зах зээлд 2023 оны 6 дугаар сард коксжих нүүрсний үнэ 99.6 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 70.8 хувиар, төмрийн хүдрийн үнэ 108.3 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар тус тус буурчээ (Зураг 1.5, 1.6). Дэлхийн аж үйлдвэрлэл үргэлжлэн саарч, эрдэс түүхий эдийн үнийн бууралт цаашид үргэлжилбэл түүхий эд экспортлогч орнуудад ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.


Аж үйлдвэрлэлийн сааралтын зэрэгцээ дэлхийн худалдааны хэмжээ 2021 оны сүүлийн хагасаас эхлэн тасралтгүй буураад байна. Тухайлбал, 2023 оны 5 дугаар сарын байдлаар дэлхийн худалдааны хэмжээ өмнөх жилийн мөн үеэс 2.4 хувиар буурав. Цар тахлын хязгаарлалт суларч, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал арилсан хэдий ч хөгжингүй орнуудын хөрөнгө оруулалт, аж үйлдвэрлэл буурч байгаа нь хөгжиж буй орнуудын үйлдвэрлэл, худалдааны хэмжээ буурахад дам нөлөө үзүүлэв.

Зураг 1.4. Дэлхийн аж үйлдвэрлэл болон худалдааны хэмжээний жилийн өөрчлөлт



Эх сурвалж: CPB Нидерланд улсын эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо.

Зураг 1.5. Алт, зэс, төмрийн хүдрийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг.

Зураг 1.6. Байгалийн хий, газрын тос, нүүрсний үнэ




Эх сурвалж: Блүүмберг, Монголбанк.

ШИГТГЭЭ 1. ХЯТАДЫН ҮЛ ХӨДЛӨХИЙН САЛБАРЫН ХҮНДРЭЛ ДААМЖИРЧ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨЛӨВ МУУДЛАА

Цар тахлын хязгаарлалт цуцлагдан, үйлчилгээний эрэлт болон хэрэглээ огцом нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил сайжирч, 2023 оны 1 дүгээр улиралд 4.5 хувиар өсөв. Үүнд иргэдийн хэрэглээний өсөлт, барилгын салбарын идэвхжил, бодлогын зарим дэмжлэг нөлөөлсөн байна. Гэвч 2023 оны 4 дүгээр сараас хойш өсөлтийн төлөв муудаж, 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өссөн нь хүлээлтээс доогуур байв. Энэ нь тус улсын эдийн засгийн идэвхжилд бодлогын дэмжлэг, хөдөлмөрийн зах зээл, өрхийн орлого, хувийн хөрөнгө оруулалтын өсөлт чухал нөлөөтэйг харуулж байна.

Зээлжих зэрэглэлийн Мүүдиз агентлагийн 2023 оны 8 дугаар сард гаргасан тайланд дурдсанаар тус улсын хүн амын насжилт нэмэгдэж, бүтээмжийн өсөлт удаашран, хөрөнгийн оруулалтын өгөөж буурч байгаа нь ирэх 3-7 жилд эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Иймд Хятадын өндөр технологийн салбарын хөгжил, дотоодын хэрэглээний өсөлт, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ зэрэг нь тус улсын эдийн засгийн өсөлтийг хангалттай дэмжиж чадвал 2023-2030 онд дунджаар 4.2 хувиар өсөх бол эдгээр хүчин зүйлс тааруу байх тохиолдолд 2023-2030 оны дундаж өсөлт 3.5 хувьд хүрч буурахаар байна (Зураг 1.7).

Зураг 1.7. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (Мүүдиз агентлаг)



Эх сурвалж: Мүүдиз агентлаг

Үл хөдлөхийн салбарыг бодлогоор дэмжиж байгаа боловч орон сууцны эрэлт бага, барилгын компаниудын өрийн дарамт өндөр байгаа нь тус салбарын сэргэлтийг удаашруулж байна.

Тухайлбал, бодлого боловсруулагчдын зүгээс ипотекийн зээлийн хүүг бууруулах, татвараас чөлөөлөх, зээлдэгчийн шаардлагыг сулруулах, барилгын компаниудын зээлийн төлөлтийг хойшлуулах, банкуудыг холбогдох зохистой харьцааны шаардлагаас түр чөлөөлөх зэргээр дэмжлэг үзүүлж байна. Гэвч үл хөдлөхийн томоохон компаниудын өрийн бүтэц өөрчлөх хэлэлцээрүүд удаашралтай байгаа нь тус салбарын цаашдын төлөвт сөргөөр нөлөөлөх болов.


БНХАУ-ын банкны системийн үйл ажиллагаа нь үл хөдлөхийн салбараас өндөр хамааралтай байна. Тодруулбал, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар банкны ипотекийн зээлийн үлдэгдэл нь 40.6 их наяд юань буюу нийт банкны салбарын зээлийн 18 хувьд хүрч, барилгын компаниудад олгосон зээл нь нийт зээлийн 5.9 хувийг эзэлж байна. Энэ нь тус улсын томоохон үл хөдлөхийн компаниудад зээл олгосон банкуудын хувьд зээлийн эрсдэл нэмэгдэж, улмаар хөрвөх чадвар болон төлбөрийн чадварын эрсдэл, эмзэг байдлыг бий болгож байна.

Эх сурвалж: Дэлхийн банк, Мүүдиз агентлаг, Trading Economics

1.2 ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Хөгжингүй орнуудад санхүүгийн нөхцөл аажим суларч байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк болон Европын төв банк тэргүүтэй зарим томоохон төв банкууд мөнгөний бодлогоо чангаруулах хурдацаа сааруулсан, технологийн салбарын идэвхжил нэмэгдэж компаниудын хувьцааны үнэ өссөн зэргээс шалтгаалан дэлхийн хөгжингүй орнуудын санхүүгийн нөхцөл 2022 оны дунд үеэс 2023 оны 6 дугаар сар хүртэл алгуур суларлаа (Зураг 1.8).

Зураг 1.8. Санхүүгийн нөхцөлийн индекс




Эх сурвалж: Олон улсын валютын сан

Хөрөнгийн зах зээлийн сэргэлт бүс нутгуудад харилцан адилгүй байна. АНУ-ын хөрөнгийн зах зээлийн S&P 500 индекс 2021 оны эцэст түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн ч дэлхий дахинд өрнөсөн геополитикийн хурцадмал байдлын нөлөөгөөр 2022 онд 19.4 хувиар унаад байв. Харин АНУ-ын инфляц сүүлийн саруудад эрчимтэй буурснаар Холбооны нөөцийн банк хүүгээ өсгөх бодлогоо дуусгавар болгон, компаниудын санхүүжилтийн зардал буурна гэсэн хүлээлт зах зээлд бий болов. Түүнчлэн, хиймэл оюун ухаан, чип үйлдвэрлэлийн цаашдын төлөв сайжирч, АНУ-ын технологийн салбарын өсөлт эрчимжиж, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдсэнээр 2023 оны эхний хагаст S&P 500 индекс өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар, Nasdaq индекс

29.0 хувиар тус тус өслөө (Зураг 1.9). Харин зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлаг энэ оны 8 дугаар сарын 2-нд ирэх гурван жилд төсвийн алдагдал нэмэгдэж болзошгүй гэсэн үндэслэлээр АНУ-ын зээлжих зэрэглэлийг “AAA” байсныг “AA+” болгон бууруулснаар S&P 500 индекс 8 дугаар сарын эцэст өмнөх сараас 1.8 хувиар унаад байна. БНХАУ-ын томоохон компаниудын хувьцаанаас бүрддэг Хонг Конгийн хөрөнгийн захын Hang Seng индекс 2022-2023 онд эрчимтэй буурав. Энэ нь БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогоос шалтгаалсан гадаадын хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээний бууралт, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналттай холбоотой юм.

Зураг 1.9. Хөрөнгийн захын гол индексүүд, 2006 = 100




Эх сурвалж: Блүүмберг.

Дэлхийн хоёр дахь том эдийн засаг болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээл ганхаж байгаа нь дэлхийн санхүүгийн зах зээлд сөргөөр нөлөөлж байна. БНХАУ-ын ДНБ-ий 20 гаруй хувийг бүрдүүлэгч үл хөдлөх хөрөнгийн салбарт хүндрэл үүсэж, тус салбарын томоохон компаниудын төлбөрийн чадвар үргэлжлэн муудаж, өр төлбөрөө төлж чадахгүй буюу дефолт болох нөхцөл байдал үүсэв. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлж, компаниудын хувьцааны үнэ буурав. Тодруулбал, Хонгконгийн

хөрөнгийн захын Hang Seng индекс 2023 оны 8 дугаар сард энэ оны эхэн үе дэх оргил түвшнээсээ 21 хувиар огцом сулрав.

Гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр зарим улс орнуудын валютын ханш ам.долларын эсрэг огцом суларлаа. Тухайлбал, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт үүссэн хүндрэлийн нөлөөгөөр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл муудаж, улмаар хөрөнгө оруулалтаа татаж байгаа нь юанийн ам.доллартай харьцах ханш сулрахад нөлөөлж байна. 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар юанийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс 5.4 хувиар сулрав (Зураг 1.10).

Зураг 1.10. Зарим орны валютын ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмберг


Тэмдэглэл: 2023.08.31-ний өдрийн ханшийг 2022.12.31-ний өдрийн ханштай харьцуулав.

Түүнчлэн, 2018 оноос эхлэн эдийн засгийн болон санхүүгийн хямралтай тулгарч буй Турк улс болон дэлхийн геополитикийн зөрчилдөөний гол оролцогч ОХУ-ын үндэсний мөнгөн тэмдэгтүүд 2023 он гарсаар ам.долларын эсрэг хамгийн ихээр суларсан байна.

Хөгжиж буй орнуудын засгийн газрын өр хурдацтай нэмэгдэж, цаашид үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Цар тахал, геополитикийн хурцадмал байдал зэрэг шокууд дараалан бий болж, улмаар улс орнууд эдийн засгаа сэргээх, тогтворжуулахад ихээхэн хэмжээний төсөв зарцуулж, тэдгээрийг өндөр

өгөөжтэй бондоор санхүүжүүлснээр засгийн газрын өрийн хэмжээ тасралтгүй өсөж байна. Тодруулбал, хөгжиж буй орнуудын засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа 2022 оны төгсгөлд 2019 оны эцсээс 9.5 нэгж хувиар, хөгжингүй орнуудын хувьд 8.4 нэгж хувиар тус тус нэмэгджээ (Зураг 1.11).

Зураг 1.11. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Геополитикийн зөрчилдөөнөөс үүдэн дэлхийн санхүүгийн нэгдмэл байдал алдагдаж³ байна. Тодруулбал, дэлхийн эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг орнуудын зөрчлөөс үүдэлтэй санхүүгийн хуваагдмал байдал нэмэгдэх нь олон улсын төлбөрийн системд саатал учруулах, хөрөнгө оруулагчдын итгэл муудаж, улмаар хөрөнгийн үнэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Түүнчлэн, хил дамнасан хөрөнгийн урсгалыг сааруулах, хөрөнгийн урсгал гэнэт татагдах, цаашлаад банкны санхүүжилтийн зардлыг өсгөх, ашигт ажиллагааг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй.

³ Financial fragmentation гэх ойлголтыг санхүүгийн нэгдмэл байдал алдагдах гэж орчуулсан болно.

ШИГТГЭЭ 2. АНУ, ЕВРОПЫН БАНКНЫ САЛБАРЫН ХҮНДРЭЛ ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН САЛБАРЫГ ДОРГИОВ.

Активын хэмжээгээрээ АНУ-ын 16 дахь банк болох Silicon Valley Bank (SVB) нь 1983 онд байгуулагдсан бөгөөд гарааны бизнес, хамтын хөрөнгө оруулалтын компаниудад санхүүжилт олгоход үйл ажиллагаа нь чиглэж байв. Цар тахлын үед (2018-2021) хамтын хөрөнгө оруулалтын компаниуд хурдацтай өссөнөөр тус банкны хадгаламж татан төвлөрүүлсэн хэмжээ эрс нэмэгдэж, үйл ажиллагаа нь эрчимтэй тэлж байсан бол 2022 он гарснаар хамтын хөрөнгө оруулалтын компаниудын санхүүжилтийн хэмжээ хумигдаж, тус банкны хадгаламж эзэмшигчдийн тоо буурахад хүргэсэн байна. Улмаар тус банк Засгийн газрын болон бусад төрлийн үнэт цаасны арилжаанаас 1.8 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн нь ил болж, хөрөнгө оруулагч нарын болгоомжлолыг нэмэгдүүлснээр 2023 оны эхээр төлөвлөж байсан өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх оролдлого нь амжилтгүй болов.

2022 оноос эхэлсэн хүүгийн огцом өсөлт нь тус банкны эзэмшиж буй томоохон хэмжээний Засгийн газрын болон бусад тогтмол хүүтэй үнэт цааснуудын бодит бус алдагдлын хэмжээг 18 тэрбум ам.долларт хүргэж, төлбөрийн чадварын хүндрэл бий болгов. Түүнчлэн, хамтын хөрөнгө оруулалтын компаниудын цаашдын төлөв муудсанаар тус банкны зээлийн багцын эрсдэл нэмэгдэж, хөрөнгө оруулагч нарын итгэл буурсан нь харилцагчид хадгаламжаа татахад хүргэн, 2023 оны 3-р сарын 10-ны өдөр тус банк дампуурлаа зарласан билээ. Үүнийг дагаад ижил секторт үйл ажиллагаа явуулдаг Signature Bank of New York (SBNY) банкны үйл ажиллагаа хөрөнгө оруулагч нарын анхаарлыг татаж, хувьцааны үнэ нь 2 өдрийн дотор 40 хувиар унав. Улмаар Нью-Йорк мужийн санхүүгийн зохицуулагч байгууллага 2023 оны 3 сарын 12-ны өдөр тус банкны дампуурлыг зарлав.

Түүнчлэн, 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойш анх удаагаа дэлхийн санхүүгийн системийн ач холбогдолтой банк дампуурахад хүрлээ. Тухайлбал, дэлхийн санхүүгийн системд чухал ач холбогдолтой банк болох Швейцарын Credit Suisse банк нь удаан хугацаанд алдагдалтай ажиллаж, олон удаагийн хяналт шалгалтын асуудалд холбогдсон нь хөрөнгө оруулагч нарын итгэлийг алдахад хүргэв. Улмаар үүнийг дагаад Европын банкуудын хувьцааны үнэ огцом унаж, зээлийн дефолт своп хэлцлийн хүүгийн зөрүү нэмэгдсэнээр дэлхийн банкны салбарын тогтвортой байдал хөрөнгө оруулагч нарын санааг зовоож эхэлж байв.

Ингээд АНУ-ын SVB болон SBNY банкны дампуурлаас 7 хоногийн дараа буюу 2023 оны 3 сарын 19-ний өдөр хүндрэлд орсон Credit Suisse банкиг Швейцарын Засгийн газрын дэмжлэгтэйгээр UBS банк 3 тэрбум Швейцар франкаар худалдан авч, өөртөө нэгтгэх шийдвэр гаргаснаа зарлалаа. Тодруулбал, Швейцарын Төв банкнаас тус банкинд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих санхүүжилт олгохоос гадна эрх баригчдын зүгээс 9 тэрбум Швейцар франкийн баталгааг UBS банкинд гаргаж, 16 тэрбум Швейцар франкийн нэрлэсэн үнэлгээ бүхий өрөөс чөлөөлөхөөр тохиролцжээ. Эдгээр банкны дампуурал нь мөнгөний захын болон санхүүгийн нөхцөл дэлхийн даяар эрчимтэй чангарснаар банкны салбарт хуримлагдаад байсан эрсдэл, эмзэг байдлыг хүндрэлд шилжихэд нөлөөлснийг харуулав. Удаан хугацаанд бага хүүтэй зах зээлд ажиллаж ирсэн зарим банкууд инфляцын дарамтаас шалтгаалсан гэнэтийн хүүгийн огцом өсөлтийн үед хүү, хөрвөх чадварын эрсдэлээ удирдаж чадсангүй. Нөгөө талдаа АНУ-ын банкны салбарт болсон үйл явдлууд хэрхэн хэвлэл, нийгмийн сүлжээгээр хурдтай тархан дэлхийн банк, санхүүгийн системд нөлөөлж, хүүгийн хүлээлтийг огцом өөрчлөн, хөрөнгө оруулагч нар эрсдэлтэй активаа зарах үйл явц болон хувирч болдгийг харууллаа.

Эх сурвалж: Олон улсын валютын сан

2. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2.1 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал тэнцэл сайжирснаар төлбөрийн тэнцлийн дарамт буурч, ашигтай гарав.

Төлбөрийн тэнцэл 2022 онд 727.2 сая ам.долларын алдагдалтай гарч байсан бол БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдсэнээс хойш манай улсын экспорт эрчимтэй өсөж, 2023 оны эхний хагаст 473.8 сая ам.долларын ашигтай гарав (Зураг 2.1). Түүнчлэн, хөрөнгө санхүүгийн данс нь 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар буурсан хэдий ч урсгал тэнцэл сүүлийн 2 улирал дараалан ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөллөө.

Нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь урсгал тэнцэл эерэг гарахад голлон нөлөөлөв.


Уул уурхайн экспортын орлого 2022 онд 36.9 хувийн өсөлттэй, 2023 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 39.8 хувийн өсөлттэй гарсан нь нүүрсний экспортын биет хэмжээ эрс нэмэгдсэнээс шалтгаалав. Улмаар төлбөрийн тэнцлийн статистикаар тооцсон барааны худалдааны тэнцэл 2022 онд 1232.5 сая ам.долларын ашигтай гарч байсан бол 2023 оны эхний хагаст 2417.7 сая ам.долларын ашигтай гарч, эрс сайжрав (Зураг 2.2).

Гэвч нөгөө талдаа үйлчилгээний импорт эрчимтэй тэлж, анхдагч орлого буюу гадаад бонд, зээл, үнэт цаас, ногдол ашгийн төлбөрийн гадагшлах урсгал өндөр хэвээр байгаа нь урсгал тэнцэлд сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн, БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын сэргэлт хүлээлтээс удаашралтай байгаа нь манай улсын нийт экспортын орлогын 70 орчим хувийг бүрдүүлдэг зэс,

нүүрс, төмрийн хүдрийн хилийн үнүүд 2023 оны эхний хагаст буурч, экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 24.2 хувиар, гадаад худалдааны нөхцөлийн индекс 16.7 хувиар тус тус муудав. Хэрэв энэ нь цаашид үргэлжилбэл Монгол Улсын экспортын орлогыг бууруулж, урсгал тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.


Зураг 2.1. Төлбөрийн тэнцэл, улирлаар /сая ам. доллар/



Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: *2023 оны 1, 2 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл.

Зураг 2.2. Барааны худалдааны тэнцэл /сая ам.доллар/, урьдчилсан гүйцэтгэл



Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар


Хөрөнгийн цэвэр орох урсгал саарч байна. Ялангуяа гадаад зээлийн төлбөрийн шилжүүлэг, багцын хөрөнгө оруулалтын гадагшлах урсгал нэмэгдсэнээс шалтгаалан хөрөнгө, санхүүгийн дансны тэнцэл 2022 онд өмнөх оноос 17.1 хувь, 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 60.7 хувиар буурав (Зураг 2.3). Засгийн газар болон хувийн хэвшлийн гадаад зээл, бондуудын томоохон төлбөрүүд хийгдэж байгаа нь хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлж байна. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт 2022 онд өмнөх оноос 17.9 хувиар, 2023 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар тус тус өссөн ба үүнд уул уурхай, олборлолтын салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна.

Төлбөрийн тэнцэл сайжирснаар гадаад валютын албан нөөц нэмэгдэв. 2022 оны эхний 3 улиралд импорт хурдтай нэмэгдэн, төлбөрийн тэнцэл муудаж, урсгал тэнцлийн алдагдал нэмэгдсэн нь гадаад валютын албан нөөцийг оны эхнээс 36.0 хувиар бууруулав. Харин 2022 оны 4 дүгээр улирлаас экспортын орлого эрчимтэй тэлж, валютын орох урсгал нэмэгдсэнээр гадаад валютын албан нөөц 2023 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өсөж, 3817.8 сая ам.долларт хүрэв. Энэ нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 4.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна (Зураг 2.4).

Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтөөс шалтгаалсан импортын тэлэлт, хүлээгдэж буй томоохон гадаад өр төлбөрүүд

төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн, дэлхийн геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдлаас шалтгаалан тодорхойгүй байдал нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширч байгаа нь түүхий эдийн үнэ, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.


Зураг 2.3. Санхүүгийн данс, улирлаар /сая ам. доллар/



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2023 оны 1, 2 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл.

Зураг 2.4. Гадаад валютын нөөц /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк


2.2 ӨРХ, ИРГЭД

Өрхийн орлого, зарлага

Цалин хөлсний өсөлтийн нөлөөгөөр өрхийн дундаж орлого нэмэгдлээ. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээгээр 2023 оны 2 дугаар улиралд өрхийн сарын дундаж орлого 2.0 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өсөв. Өрхийн орлого ийнхүү нэмэгдсэн нь төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр тэтгэмж нэмэгдэж, үүнийг дагаад хувийн хэвшлийн ажилчдын цалин өссөнтэй холбоотой юм.

Бодит цалин сүүлийн 4 улирал дараалан өсөв. Улсын дундаж цалин 2023 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар нэмэгдэж, 1.8 сая төгрөгтэй тэнцэж байна. Нэрлэсэн цалин өсөж, инфляц буурч байгаагаас шалтгаалан бодит цалингийн өсөлт нэмэгдээд байна. Тухайлбал, 2023 оны 1 дүгээр улиралд бодит цалингийн жилийн өсөлт 12.7 хувьд хүрсэн нь 2013 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм (Зураг 2.5).

Зураг 2.5. Нэрлэсэн болон бодит цалингийн өсөлт, инфляцын түвшин



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ийнхүү өрхийн дундаж орлого нэмэгдсэн хэдий ч, өрхийн зарлага орлогоос илүү хурдтай тэлж байна. 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн эдийн засгийн идэвхжил сэргэж өрхийн хэрэглээ нэмэгдсэн болон үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн зарлага орлогоосоо давж эхэллээ. Өрхийн зарлага


2023 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар нэмэгдсэний 15.2 нэгж хувийг хүнсний бус зардал, тэр дундаа орон сууц, ус, цахилгаан болон тээврийн хэрэгслийн зардлын өсөлт бүрдүүлэв. Цаашид өрхийн орлого, зарлагын зөрүү үргэлжлэн өсвөл зөрүүг зээлээр санхүүжүүлснээр өрхийн өр нэмэгдэж, өрийн дарамтад орох эрсдэлтэй (Зураг 2.6).

Зураг 2.6. Өрхийн дундаж орлого, зарлага болон зөрүү /мянган төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.7. Хөдөлмөрийн захын үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн захын голлох үзүүлэлтүүд сайжирч цар тахлын өмнөх түвшинд ойртож байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2018-2019 онд харьцангуй тогтвортой буюу 60 орчим хувьтай байсан бол цар тахлын нөлөөгөөр эрчимтэй буурч 2021 оны 1 дүгээр улиралд 54.9 хувьд хүрээд байв. Харин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 58.0

хувь болж эргэн сэргээд байна. Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 54.5 хувьд хүрч цар тахлын өмнөх түвшинд ойртож байна. Харин, ажилгүйчүүдийн тоо буурснаас үүдэн ажилгүйдлийн түвшин буурч 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 5.8 хувьд хүрлээ (Зураг 2.7).

Иргэдийн зээл, орон сууцны үнэ


2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудын¹ иргэдийн зээлийн үлдэгдэл 20.6 их наяд төгрөгт хүрэв. Тодруулбал, иргэдийн нийт зээлийн 67.0 хувийг банк, 18.6 хувийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон ипотекийн зээл, 13.3 хувийг ББСБ-ийн зээл, 1.1 хувийг ХЗХ-ны зээл тус тус бүрдүүлж байна. Харин банканд хамаарах зээлийг зориулалтаар нь авч үзвэл 54.3 хувийг хэрэглээний зээл, 22.3 хувийг ипотекийн зээл, 19.3 хувийг ЖДҮ-ийн зээл эзэлж байна (Зураг 2.8).

Иргэдийн зээлийн өсөлтийн гол хэсгийг хэрэглээний зээл болон ипотекийн зээлийн өсөлт бүрдүүлж байна. Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн нөлөөгөөр 2021 оны дунд үеэс эрчимтэй өсөж эхэлсэн санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээлийн хэмжээ 2023 оны 6 дугаар сарын эцэст өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар өслөө. Энэхүү өсөлтийн 9.0 нэгж хувийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлжээ. Энэ нь нэг талаас цалин, тэтгэврийн өсөлттэй холбоотойгоор өрхийн нэрлэсэн орлого өсөж, улмаар өр-орлогын харьцааны хязгаарлалтын хүрээнд авах боломжтой банкны зээлийн дүн нэмэгдсэн, нөгөө талаас инфляцын нөлөөгөөр иргэдийн худалдан авах чадвар буурч, өрхүүд орлого, зарлагын зөрүүгээ зээлээр

¹ Банк, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо болон Монголын ипотекийн корпораци.


санхүүжүүлж байгаатай холбоотой юм (Зураг 2.9).

Зураг 2.8. Өрхийн өрийн бүтэц, их наяд ₮



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 2.9. Иргэдийн зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо


Түүнчлэн, ипотекийн зээлийн өсөлт 2018 оноос 2020 он хүртэлх хугацаанд 3.4-6.7 хувьтай байсан бол эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийн хүү буурч, зээлийн эх үүсвэр, санхүүжилт нэмэгдсэнээр² 2021 оны дунд үеэс хойш өсөлт эрчимжсэн. 2023 оны 2 дугаар улиралд иргэдийн ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өслөө.

Өрхийн жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн өсөлт удааширч байна. Иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл 10 их

² 2021-2023 оны хооронд 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд нийт 1.9 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээл олгосон байна.

наядын хөтөлбөрийн нөлөөгөөр 2021 оны эцэст өмнөх оны мөн үеэс 58.5 хувиар өсөж байв. Харин 2023 оны 2 дугаар улирлын эцэст тус зээлийн өсөлт 16.6 хувь болж удаашрав (Зураг 2.10).

Зураг 2.10. Иргэдийн зээлийн бүрэлдэхүүн / жил бүрийн 2 дугаар улирал/




Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Энэ оны эхнээс ипотекийн зээлийн эргэн төлөлт хийгдэж эхэлснээр зээлийн эргэлт хурдсаж байна. Тодруулбал, энэ оны эхний хагаст олгосон зээлийн болон төлөгдсөн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 9.2 болон 54.1 хувиар тус тус өсжээ (Зураг 2.11). Тухайн улиралд шинээр олгосон ипотекийн зээлийн хувьд 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн Монголбанкны эх үүсвэрийн санхүүжилтээс гадна арилжааны банкны өөрийн эх үүсвэрийн зээл эрчимтэй нэмэгдсэн байна.

Банкны салбараас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдлийн өр орлогын харьцаа (ӨОХ) аажим өсөж байна. Тодруулбал, банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлд ӨОХ-ны хязгаарлалт хэрэгжиж эхэлсэн 2019 оноос хойш дундаж ӨОХ тогтмол буурч байсан хэдий ч, 2022 оноос эхлэн алгуур нэмэгдэж 2023 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 52.8 хувьд хүрээд байна (Зураг 2.12). Энэ нь өрхийн өрийн үйлчилгээний төлбөрийн дарамт нэмэгдэж буйг илтгэж байна.


Түүнчлэн, Монголбанкнаас тогтоосон иргэдийн хэрэглээний зээлийн ӨОХ-ны хязгаарлалтаас давуулан ББСБ-аас зээл нэмж авсан, банк болон ББСБ-ын давхар зээлтэй иргэдийн хувьд дундаж ӨОХ 80 орчим хувь байгаа нь эдгээр зээлдэгчдийн хувьд бодит өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна (Бүлэг 4.2).

Зураг 2.11. Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл болон хагас жилд олгосон, төлөгдсөн зээл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.12. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн дундаж өр, орлогын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Банк бус санхүүгийн байгууллагаас олгосон иргэдийн зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдлээ. Тодруулбал, 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ББСБ-ын иргэдийн зээлийн үлдэгдэл 2.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар, 2018 оны эцсээс 3.8 дахин нэмэгджээ. Үүнд СЗХ-ны шийдвэрээр ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2018-2021 онуудад үе шаттайгаар

нэмэгдүүлсэн, түүнчлэн гар утасны програм, техник, технологийн дэвшлийн нөлөөгөөр Финтекийн салбарын үйл ажиллагаа эрчимжсэн нь голлон нөлөөлсөн байна. Нөгөөтэйгүүр, банкуудаас иргэдэд олгох хэрэглээний зээлийн хязгаарлалт бүхий макро зохистой бодлогын нөлөөгөөр зарим иргэдийн хэрэглээний зээл нь ББСБ-уудын зах зээл рүү шилжиж, ББСБ-уудын иргэдийн зээлийн өсөлтөд нөлөөлж байна.

Цар тахлын үеийн бодлогын арга хэмжээнүүд дуусгавар болсны дараа банкны бус санхүүгийн салбар дахь иргэдийн зээлийн чанар бага зэрэг муудах хандлагатай байгаа бол банкны салбар дахь иргэдийн зээлийн чанар харьцангуй тогтвортой байна. Тодруулбал, ипотекийн зээлийн эргэн төлөлт хийгдэж эхэлсэн буюу 2023 оны 1 дүгээр сараас хойш ББСБ болон хадгаламж зээлийн хоршооны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өсөх хандлагатай байна. Энэ нь банкны ипотекийн болон банкны бус санхүүгийн салбарын давхар зээлтэй зарим иргэд өрийн дарамтад орж, зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч буйг илтгэж байна (Зураг 2.13).


Цар тахлын тухай³ хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон үе буюу 2022 оны эцэст нийт ипотекийн чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн харьцаанууд харгалзан 1.2 хувь болон 0.8 хувь байсан бол 2023 оны 6 дугаар сарын байдлаар харгалзан 1.3 хувь болон 1.4 хувь болж өсөөд байна (Зураг 2.14). Гэвч банкны салбараас олгосон нийт иргэдийн зээлийн хувьд чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ харьцангуй тогтвортой байна.

Орон сууцны үнэ сүүлийн 6 улирлын турш тогтвортой хадгалагдаж байна. Орон сууцны үнэ ипотекийн зээлийн санхүүжилт,

³ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

барилгын өртгийн өсөлт зэрэг эрэлт, нийлүүлэлтийн давхар шокийн нөлөөгөөр 2020-2021 онуудад эрчимтэй өссөн бол 2022 оны эхнээс тогтворжив. (Зураг 2.15).

Зураг 2.13. Иргэдийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь /жил бүрийн 2 дугаар улирал/



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: ББСБ-ын нийт чанаргүй зээлийн үзүүлэлтийг ашигласан болно.

Зураг 2.14. Ипотекийн зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.15. Орон сууцны үнэ болон өртгийн индекс, 2019 = 100




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Тэнхлэг зууч.

2.3 АЖ АХУЙН НЭГЖ


Эдийн засгийн сэргэлтийг даган үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэн боловч үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон аж ахуйн нэгжүүдийн тоо мөн өсөв. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 89.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар нэмэгдлээ. Үүний дотор худалдаа, боловсруулах, тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн тоо бусад салбартай харьцуулахад илүү ихээр нэмэгдсэн байна (Зураг 2.16).

Зураг 2.16. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /мянга/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.17. Үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо /мянга/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гэвч 2023 оны 2 дугаар улиралд үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо өмнөх оны мөн үеэс 1.2 мянгаар буюу 45.6 хувиар нэмэгдэж, 3.9 мянгад хүрээд

байна. Тодруулбал, өмнөх оны мөн үеэс хойш худалдааны салбарт хамгийн их буюу 626 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа бүрэн зогсоогоод байна (Зураг 2.17).

Эдийн засгийн дийлэнх салбаруудын үйл ажиллагаа сэргэж, борлуулалт нэмэгдлээ. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн ихэнх салбарын борлуулалтын орлого өсөв. Тухайлбал, уул уурхайн салбарын борлуулалтын орлого 17.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.1 дахин нэмэгдсэн бөгөөд уул уурхайн салбараас өндөр хамааралтай худалдаа, тээврийн салбарын борлуулалтын орлого харгалзан 20.3 их наяд, 1.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.0, 101.3 хувиар тус тус өслөө (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1 Эдийн засгийн салбаруудын борлуулалтын орлого /тэрбум төгрөг/


Салбар	2021.06	2022.06	2023.06	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Аж үйлдвэр	12 275	11 578	21 358	9 780	84.5%
Уул уурхай	8 896	8 002	16 696	8 695	108.7%
Боловсруулах	2 589	2 731	3 574	842	30.8%
Цахилгаан, хий	709	750	971	221	29.4%
Ус хангамж	81	95	113	18	19.0%
Худалдаа	12 453	16 792	20 314	3 522	21.0%
Тээвэр	676	757	1 524	767	101.3%
Төмөр зам	393	325	526	201	61.6%
Агаарын тээвэр	72	150	358	209	139.5%
Авто замын тээвэр	211	282	640	358	126.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Банкны салбар дахь хувийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 11.2 их наяд төгрөгт хүрлээ. Үүний 32.0 хувийг худалдаа, 16.3 хувийг барилга, 15.7 хувийг боловсруулах, 11.2 хувийг уул уурхай, 24.8 хувийг бусад салбарын зээл тус тус бүрдүүлж байна (Зураг 2.18). Харин улсын байгууллагын нийт зээлийн үлдэгдэл 157.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 26.8 хувийг боловсруулах, 46.1 хувийг тээвэр,

агуулахын салбарын зээл бүрдүүлж байна.


Зураг 2.18. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл, салбаруудаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн, хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 2.8 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 16.7 нэгж хувиар буураад байна. Эдийн засгийн салбаруудын дотор уул уурхай, худалдаа, барилгын салбарын зээлийн өрийн үлдэгдлийн өсөлт саарав (Зураг 2.19).

Зураг 2.19. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт, салбаруудаар, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн төвлөрөл өндөр хэвээр байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийн 75.2 хувийг эдийн засгийн гол дөрвөн салбар буюу худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна. Энэ нь банкны санхүүгийн зуучлал,

ашигт ажиллагаа эдгээр салбаруудаас өндөр хамааралтай хэвээр байгааг харуулж байна (Зураг 2.20).


Зураг 2.20. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн төвлөрөл /салбараарх/



Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн, нийт хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн 40.2 хувь нь 5 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй 243 тооны дансанд төвлөрч байгаа нь банкны салбарт зээлийн төвлөрлийн эрсдэл өндөр байгааг илэрхийлж байна (Зураг 2.21).

Зураг 2.21. Хувийн байгууллагын зээлийн төвлөрөл, зээлийн дүнгээр /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн өсөлт нэмэгдлээ. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар хувийн байгууллагад олгосон зээлийн өсөлт 8.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.8 нэгж хувиар нэмэгдээд байна. Үүний дотор эдийн засгийн голлох

⁴ Хөтөлбөрийн болон хөнгөлөлттэй зээлийг хассан дүн.

салбаруудаас хөдөө аж ахуй, тээврийн салбарт шинээр олгосон зээлийн өсөлт өндөр байгаа бол худалдаа, барилга, боловсруулах салбарт удааширлаа (Зураг 2.22).

Зураг 2.22. Хувийн байгууллагын олгосон зээлийн өсөлт, салбаруудаар, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь харьцангуй тогтвортой байна. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн үлдэгдэл 2023 оны 2 дугаар улиралд өмнөх жилийн мөн үеэс 3.4 хувиар буюу 55.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Харин чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 15.2 хувь байна. Уул уурхай, барилга үл хөдлөх, боловсруулах салбарын чанаргүй зээл нийт чанаргүй зээлийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байна (Зураг 2.23).


Түүнчлэн, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар уул уурхайн салбарын чанаргүй зээлийн уул уурхайн салбарын нийт зээлд эзлэх хувь 33.1 хувь, боловсруулах салбарын чанаргүй зээлийн боловсруулах салбарын нийт зээлд эзлэх хувь 22.8 хувь буюу харьцангуй өндөр түвшинд байна (Зураг 2.24).

Зураг 2.23. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн хувь, салбараарх бүрэлдэхүүн




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.24. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн харьцаа, салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.25. Олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өслөө. Инфляцыг бууруулах зорилгоор бодлогын хүүг 2022 онд 4 удаа дараалан нэмэгдүүлсэн нь банкуудын зээлийн хүү нэмэгдэхэд нөлөөлөв. Тухайлбал, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.2 хувьд хүрч өмнөх


оны мөн үеэс 2.3 нэгж хувиар нэмэгдлээ. Үүний дотор барилга, уул уурхайн салбарт олгох зээлийн жигнэсэн дундаж хүү өндөр байгаа бол “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд олгож буй хөнгөлөлттэй зээлийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарт олгох жигнэсэн дундаж хүү 9.4 хувьд хүрч эрчимтэй буурлаа (Зураг 2.25).

2.4 УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсөв

Эдийн засгийн идэвхжилээс шалтгаалан төсвийнтэнцэлонөхнийхагасынбайдлаар эерэг гарлаа. 2023 оны эхний хагас жилийн Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 10.58 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 44.0 хувиар нэмэгдсэн бол нийт зардал 9.03 их наяд төгрөгт хүрч өмнөх оны үеэс 10.3 хувиар нэмэгдлээ. Ингэснээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1.55 их наяд төгрөгийн ашигтай гарав (Зураг 2.26).

Зураг 2.26. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний хагас, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн орлого уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүний экспортоос ихээхэн хамааралтай байна. Эдийн засгийн идэвхжил, түүхий эдийн экспортын таатай нөхцөл байдал үргэлжилснээр төсвийн орлого бүрдүүлэлт өндөр байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 30 орчим хувь нь уул уурхайн салбараас шууд болон шууд бусаар хамаарч байна. БНХАУ “Тэг Ковид” бодлогоо цуцлан хилээ нээснээр Монгол Улсын нүүрсний экспорт сэргэж, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нүүрсний экспортын биет хэмжээ 29.5 сая сая тоннд хүрч эрс нэмэгдлээ.


2023 оны эхний хагаст төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар өссөн бөгөөд үүнд ААН-ийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өсөлт голлон нөлөөлөв (Хүснэгт 2.2).

Хүснэгт 2.2. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний хагас, их наяд төгрөг)

Орлого	2021	2022	2023	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
ААНОАТ	1 356	989	1 781	793	80.2%
АМНАТ	226	804	1 734	930	115.7%
НӨАТ	1 346	1 804	2 182	378	20.9%
Нийгмийн даатгалын орлого	995	1 386	1 795	409	29.5%
Бусад орлого	3 183	3 018	3 566	548	18.2%
Нийт төсвийн орлого	7 106	8 002	11 059	3 058	38.2%

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 2.27. Нэгдсэн төсвийн зарлагын жилийн өсөлтийн бүрэлдэхүүн (жил бүрийн эхний хагас)



Эх сурвалж: Сангийн яам

Нийгмийн халамж болон төсвийн хөрөнгө оруулалт нэгдсэн төсвийн зардлын өсөлтийн ихэнх хэсгийг бүрдүүлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн халамж болон хөрөнгө оруулалтын зардал ихээхэн нэмэгдсэн нь төсвийн зардал өсөхөд голлон нөлөөллөө (Зураг 2.27). Тухайлбал, нийгмийн халамж болон төсвийн


хөрөнгө оруулалтын зардал өмнөх оны мөн үеэс харгалзан 248.5 болон 24.6 хувиар өсөв.

Улсын гадаад өр

Монгол Улсын гадаад өрийн дарамт өндөр хэвээр байна. Монгол Улсын нийт гадаад өр 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 33.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны үеэс 2.4 хувиар өслөө. Нийт гадаад өрийн 23.6 хувь буюу 8.0 тэрбум ам.долларыг Засгийн газар, 5.9 хувь буюу 2.0 тэрбум ам.долларыг төв банк, 5.0 хувь буюу 1.7 тэрбум ам.долларыг хадгаламжийн байгууллага, 24.7 хувь буюу 8.4 тэрбум ам.долларыг бусад салбаруудын гадаад өр бүрдүүлж байгаа бол 40.8 хувь буюу 13.8 тэрбум ам.долларыг компани хоорондын зээллэг бүрдүүлж байна (Зураг 2.28). Түүнчлэн, компани хоорондын зээллэгийн 80.4 хувь буюу 11.1 тэрбум ам.доллар нь Оюутолгой ХХК-ий компани хоорондын зээллэг байна.


2031 он хүртэл Монгол Улсын Засгийн газар нийтдээ 2.6 тэрбум ам.долларын бондын эргэн төлөлтийг хийх хуваарьтай байна. Тодруулбал, 2023 оны 10, 12 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн банк 400 сая ам.долларын Евро бонд, 30 тэрбум иенийн⁵ Самурай бондыг тус тус эргэн төлөх хуваарьтай байгаа бол Засгийн газар 2024 онд Хуралдай бондын 391 сая ам.доллар, 2026 онд Номад бондын 600 сая ам.доллар, 2027 онд Сенчюри-2027 бондын 500 сая ам.доллар, 2028 онд Сенчюри-2028 бондын 650 сая ам.доллар, 2031 онд Сенчюри-2031 бондын 500 сая ам.долларын эргэн төлөлтийг тус тус хийхээр байна (Зураг 2.29).

Зураг 2.28. Монгол Улсын гадаад өрийн бүтэц, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Сангийн яам

Зураг 2.29. Засгийн газар болон Хөгжлийн Банкны гадаад бондын төлбөрийн хуваарь, сая ам.доллар (2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар)



Эх сурвалж: Сангийн яам, Хөгжлийн Банк

⁵ 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн ханшаар 207 сая ам.доллар болж байгааг Зураг 2.29-т харуулав.


ШИГТГЭЭ 3. САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ

“Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал” нь санхүүгийн системийн эмзэг байдлын ерөнхий дүр зургийг харуулах, бодлого боловсруулагч болон зах зээлд оролцогчдод зах зээлд үүсэж болзошгүй эрсдэлийн талаарх чиг хандлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Монгол Улсын санхүүгийн салбарын эмзэг байдлыг илтгэгч үзүүлэлтүүдийг (i) макро эдийн засаг, (ii) гадаад сектор, (iii) мөнгөний зах, (iv) хөрвөх чадвар, санхүүжилт, (v) банкны салбарын ашигт ажиллагаа, (vi) хөрөнгийн зах зээл, (vii) өрхийн сектор гэсэн эрсдэл үүсэх боломжит ангиллаар бүлэглэн, эрсдэлийн түвшинг жил, улирал, сарын давтамжтайгаар тодорхойлж байна.

2022 оны эхэнд геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалан гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширсны зэрэгцээ БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдсоноор Монгол Улсын гадаад сектор, макро эдийн засаг, мөнгөний зах зээл, банкны секторын эрсдэл нэмэгдэж, санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексийн утга өсөв.

Харин 2022 оны дунд үеэс хилийн хязгаарлалт суларснаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил сэргэсний зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний нөлөөгөөр дээрх эрсдэлүүд үргэлжлэн буурч, санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексийн утга харьцангуй бага түвшинд хүрээд байна (Зураг 2.30). Тухайлбал, экспортын орлого сэргэснээр төлбөрийн тэнцэл сайжирч, гадаад валютын нөөц нэмэгдсэний зэрэгцээ долларжилт, зээлийн өсөлт тогтворжиж байгаа нь макро эдийн засаг, гадаад сектор, мөнгөний захын эрсдэлийг бууруулж байна (Зураг 2.31).

Зураг 2.30. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс /2023 оны 2 дугаар улирлын байдлаар/



3. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

3.1 БАНКНЫ САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Банкны салбарын нийт актив үргэлжлэн өсөв. 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар банкны салбарын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буюу 5.7 их наяд төгрөгөөр өсөж, 47.7 их наяд төгрөгт хүрэв (Зураг 3.1). Нийт активыг бүтцээр нь авч үзвэл зээлийн үлдэгдэл 48.8 хувь, мөнгөн хөрөнгө 21.7 хувь, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 14.9 хувь, Засгийн газрын үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 2.7 хувь, бусад хөрөнгө 11.9 хувийг тус тус эзэлж байна (Зураг 3.2).

Активын өсөлтийг зээл болон Төв банкны үнэт цаасанд байршуулсан хөрөнгийн өсөлт голлон тодорхойлж байна. Банкны системийн нийт зээлийн эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөж, 23.3 их наяд төгрөгт хүрсэн бол Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 32.5 хувиар буюу 1.7 их наяд төгрөгөөр өсөж, 7.1 их наяд төгрөг болов. Тайлант улиралд системийн нийт активт цэвэр зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар буурсан бол Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2.1 нэгж хувиар өссөн байна (Зураг 3.2).

Эх үүсвэрийн өсөлтийн дийлэнх хувийг харилцах, хадгаламжийн өсөлт бүрдүүлж байна. 2023 оны 2 дугаар улиралд банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар буюу 5.0 их наяд төгрөгөөр өсөж, 42.5 их наяд төгрөгт хүрэв. Тухайлбал, харилцах дансны үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.8 хувиар буюу 2.6 их наядаар өсөж, 11.9 их наяд төгрөгт


хүрсэн бол хадгаламжийн дансны үлдэгдэл 5.5 хувиар буюу 1.0 их наядаар өсөж, 19.2 их наяд төгрөг болов.

Зураг 3.1. Банкны системийн актив, бүрэлдэхүүнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.2. Банкны системийн активын бүтэц /их наяд төгрөг, 2022.06 сар болон 2023.06 сарын байдлаар/



Эх сурвалж: Монголбанк


Иргэдийн зээлийн өсөлт нь нийт зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлсэн хэвээр байна. Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 их наяд төгрөгөөр өсөж, 25.3 их наяд төгрөгт хүрээд байна. Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн нөлөөгөөр 2022 оны эхний хагас жилд өндөр өсөлттэй байсан банкны салбарын зээлийн өсөлт 2022 оны 2

дугаар улирлаас эхлэн саарах хандлагатай болов. Харин 2023 оны 2 дугаар улиралд тогтвортой түвшинд хадгалагдан нийт активын өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Тайлант хугацааны эцэст зээлийн жилийн өсөлт 7.9 хувь байгаа бөгөөд энэхүү өсөлтийн 7.7 нэгж хувь нь иргэдийн зээл, 0.2 нэгж хувь нь байгууллагын зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Бизнесийн зээлийн өсөлт саарч байгаа нь бодит эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Зээлийн өсөлтийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн зээл 20.1 хувиар буюу 1.8 их наяд төгрөгийн өсөлт үзүүлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт бол боловсруулах үйлдвэрлэлийн зээл 11.1 хувиар буюу 183.2 тэрбум төгрөгөөр, худалдааны салбарын зээл 3.6 хувиар буюу 187.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Харин уул уурхайн салбарын зээл 24.3 хувиар буюу 450.1 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй байна. (Зураг 3.3).

Зураг 3.3. Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар (2023.06.30), тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн чанаргүй зээл

2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн 86.4 хувь буюу 21.8 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 5.4 хувь буюу 1.4 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 8.1 хувь буюу 2.0 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагдаж, нийт эргэн төлөлтийн доголдолтой зээлийн¹ дүн 3.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна (Зураг 3.4).

2023 оны 2 дугаар улирлын байдлаар банкны салбарын анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буюу 53.2 тэрбум төгрөгөөр буурсан боловч, чанаргүй зээлийн үлдэгдэл 7.0 хувиар буюу 135.6 тэрбум төгрөгөөр өсснөөр нийт эргэн төлөлтийн доголдолтой зээлийн үлдэгдэл

82.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Эргэн төлөлтийн доголдолтой зээлийг эдийн засгийн салбараар авч үзвэл, өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилга, уул уурхай, үл хөдлөх хөрөнгө (ипотек)-ийн салбарын зээлийн чанар үргэлжлэн муудсан байна.

Зураг 3.4. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк


¹ Чанаргүй зээл болон анхаарал хандуулах зээлийн нийлбэр дүн

Чанаргүй зээлийн жилийн өсөлтийг голлох эдийн засгийн салбараар авч үзвэл худалдааны салбарын чанаргүй зээл 187.4 тэрбум төгрөгөөр буюу 140.1 хувиар, барилгын салбарын чанаргүй зээл 97.3 тэрбум төгрөгөөр буюу 36.1 хувиар, иргэдийн хэрэглээ, ЖДҮ-ийн чанаргүй зээл 60.2 тэрбум төгрөгөөр буюу 16.9 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн (Зураг 3.7). Харин чанаргүй зээлийн хувьд уул уурхайн салбарын чанаргүй зээл 121.4 тэрбум төгрөгөөр буюу 23.0 хувиар, үл хөдлөх хөрөнгө (ипотек)-ийн чанаргүй зээл 21.1 тэрбум төгрөгөөр буюу 12.8 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн чанаргүй зээл 20.6 тэрбум төгрөг буюу 7.4 хувиар тайлант улиралд буурсан үзүүлэлттэй гарлаа (Зураг 3.7).

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдэх хандлагатай байна. Банкны системийн активын жилийн өсөлтийг мөнгөн хөрөнгө болон Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт голлон бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн нийт активт эзлэх хувь буурч, бизнесийн зээлийн өсөлт саарч байгаа нь банкууд активын эрсдэлийг бууруулж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлж байгааг харуулж байна. Энэхүү хандлага нь бодит эдийн засгийн эрсдэлийн түвшинээс гадна банкны системд нөлөө бүхий банкууд


олон нийтэд хувьцаагаа гаргаж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн, банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй байна.

Зураг 3.5. Чанаргүй, анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.6. Зээлийн эрсдэлийн сан, чанаргүй зээлийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.7. Чанаргүй зээлийн үлдэгдэл ба жилийн өсөлт, салбараар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

ШИГТГЭЭ 4. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Зээлийн нөхцөл: 2023 оны 2 дугаар улирлын байдлаар банкуудын ААН болон иргэдийн зээлийн нөхцлийн дундаж индекс бага зэрэг сулрах мужид байна. Том банкууд сүүлийн улиралд зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бол ААН-ийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй байна. Харин дунд болон жижиг банкууд зээлийн нөхцөлөө хэвээр үлдээв. Ирэх улиралд банкууд дунжаар ААН, иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулах төлөвтэй байна. Том банкууд ААН-ийн, дунд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулах хүлээлттэй байна (Зураг 3.8).

Зээлийн шалгуур: Тайлант хугацаанд банкуудын ААН, иргэдийн зээлийн шалгуурын дундаж индекс мөн бага зэрэг сулрах мужид байна. Тодруулбал, том банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол жижиг болон дунд банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна (Зураг 3.9). Зээлийн шалгуур сулрахад эх үүсвэрийн зардал, боломж, өрсөлдөөн, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон банкны эрсдэл даах чадвар сайжирсан нь голлон нөлөөллөө. Харин ирэх улиралд банкууд ААН, иргэдийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах хандлагатай байна.


Зээлийн эрэлт: Тайлант хугацаанд банкууд ААН-ийн зээлийн эрэлтийн дундаж индекс нэлээд нэмэгдсэн мужид байгаа бол иргэдийн зээлийн эрэлтийн дундаж индекс бага зэрэг нэмэгдсэн мужид байна (Зураг 3.10). Тухайлбал, том болон дунд банкуудын хувьд иргэд болон ААН аль алиных нь зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн бол жижиг банкуудын зээлийн эрэлтэд өөрчлөлт ороогүй байна. ААН-ийн зээлийн эрэлт нэмэгдэхэд эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хүсэлт өссөн нь нөлөөлсөн бол иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэхэд эдийн засгийн нөхцөл байдлын талаар хэрэглэгчдийн итгэл нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ. Ирэх улиралд банкны системд зээлийн эрэлт нэмэгдэх хүлээлттэй байна. Тодруулбал, том болон дунд банкууд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэхээр байгаа бол жижиг банкууд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

Зээлийн нийлүүлэлт: Тайлант хугацаанд банкууд ААН, иргэдийн зээлийн нийлүүлэлтээ ихээхэн нэмэгдүүллээ. Ирэх улиралд банкууд ААН, иргэдийн зээлийн нийлүүлэлтийг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Тодруулбал, том болон дунд банкууд ирэх 3 сард зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байгаа бол жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах хандлагатай байна. Ялангуяа иргэдийн зээлийн хувьд цалингийн, тэтгэврийн, хэрэглээний болон автомашины зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байна.


Зураг 3.8. Зээлийн ерөнхий нөхцлийн индекс



Зураг 3.9. Зээлийн шалгуурын индекс



Зураг 3.10. Зээлийн эрэлтийн индекс



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн 2023 оны II улирлын түүвэр судалгааны тайлан.
Монголбанк (2023).

3.2 БАНКНЫ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.2.1 Банкны салбарын эрсдэлийн үзүүлэлт

Банкны салбарын голлох тоон мэдээллүүд болон зохистой харьцааны үзүүлэлтүүдэд үндэслэн тооцдог банкны системийн эрсдэлийн нэгдсэн индекс 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 0.18 нэгжид хүрч, өмнөх оны мөн үеэс 0.15 нэгжээр буурсан нь банкны системийн эрсдэл буурсныг илтгэж байна (Зураг 3.11 болон Зураг 3.12). Тодруулбал:


- 1. Зээлийн эрсдэл.** Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, инфляцын өсөлт саарч, улмаар ААН, иргэдийн төлбөрийн чадвар сайжирснаар 2023 оны 2 дугаар улиралд банкны зээлийн эрсдэлийн индекс буурлаа.
- 2. Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.** Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2023 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар нэмэгдэж 39.0 хувьд хүрэв.
- 3. Ашигт ажиллагаа.** 2023 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбар 606.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, улмаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын

өгөөж харгалзан 23.0 болон 2.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.2 болон 0.9 хувиар тус тус нэмэгдэв.

- 4. Зах зээлийн эрсдэл.** Тайлант улиралд гадаад валютын зээл, хадгаламжийн харьцаа өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Түүнчлэн, 2023 оны 6 дугаар сарын байдлаар банкны системийн нийт гадаад валютын позицын харьцаа үзүүлэлт -10.6 хувьтай буюу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. 2023 оны 6 дугаар сарын байдлаар банкны системийн нийт өөрийн хөрөнгө болон 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт өмнөх оны мөн үеэс тус бүр 1.3 нэгж хувиар нэмэгдэж, 16.8 хувьд хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна. Банкны системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн нь банкуудын өөрийн хөрөнгө нэмэгдэх, улмаар харьцаа үзүүлэлтүүд сайжрахад нөлөөллөө.

Зураг 3.11. Банкны системийн эрсдэлүүд (Дэд бүлгээр, 2023.06 сар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.12. Эрсдэлийн зураглал




Эх сурвалж: Монголбанк

3.2.2 Банкны салбарын эх үүсвэрийн долларжилт

Банкны салбарын зээлийн долларжилтын хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч байгаа хэдий ч **харилцах, хадгаламжийн долларжилт нь валютын ханшийн хөдөлгөөнөөс шалтгаалан өндөр түвшинд хадгалагдаж байна.** Тухайлбал, төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байсан 2020-21 онд гадаад валютын харилцах, хадгаламжийн хэмжээ алгуур буурч, харин 2022 оны ханшийн огцом сулралтын үед буцаад эрчимтэй өсөв (Зураг 3.13).

Зураг 3.13. Иргэд, ААН-ийн гадаад валютын харилцах, хадгаламж болон ханш




Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү банкуудын эх үүсвэрийн долларжилтын түвшин өндөр байх нь баланс дахь валютын төрлийн зөрүүтэй байдал (currency mismatch)-ыг бий болгон, хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлж, банкыг дотоод валютын эх үүсвэрийн дутагдалд оруулах, цаашлаад мөнгөний бодлого, түүний шилжих механизмын нөлөөг сулруулах, тогтворгүй өндөр инфляци, ханшийн хэлбэлзлийг үүсгэх, хүүний зөрүүг нэмэгдүүлэх, санхүүгийн системийг хямралд өртөмтгий, эмзэг болгох зэрэг сөрөг нөлөөтэй. Монгол Улсын банкны салбарын активын долларжилтын хэмжээ 2023 оны 6 дугаар сарын байдлаар 6.1 хувь, эх үүсвэрийн долларжилтийн хэмжээ 28.6

хувь байна (Зураг 3.14). Эх үүсвэрийн дотор нийт харилцахын долларжилт 32.2 хувьтай байгаа бол хадгаламжийн долларжилт 26.5 хувь байна. Түүнчлэн, 2019.01.01-ний өдрийн ам.долларын ханшид үндэслэн тооцсон харилцах, хадгаламжийн бодит долларжилт 23.5 хувь байгаа бөгөөд үүнээс харилцахын бодит долларжилт 26.8 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 7.3 нэгж хувиар буураад байгаа бол хадгаламжийн бодит долларжилт 21.7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар нэмэгдэв.

Зураг 3.14. Зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Бодит долларжилт нь 2019.01.01-ний өдрөөс хойших ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцсон үзүүлэлт болно.


Гадаад валютын хадгаламжийн хэмжээ 2023 оны 6 дугаар сарын байдлаар 4953.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаагаас 3755.6 тэрбум төгрөгийг (75.8%) иргэд, 1021.0 тэрбум төгрөгийг (20.6%) хувийн байгууллага, 161.8 тэрбум төгрөгийг (3.3%) улсын байгууллага, 14.9 тэрбум төгрөгийг (0.3%) бусад байгууллагын гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байна (Зураг 3.15).

Харин гадаад валютын харилцах 3409.5 тэрбум төгрөг байгаагаас 2158.4 тэрбум төгрөгийг (63.3%) хувийн байгууллага, 608.9 тэрбум төгрөгийг (17.9%) иргэд, 585.4 тэрбум төгрөгийг (17.2%) улсын байгууллага, 56.8 тэрбум төгрөгийг (1.7%) бусад байгууллагын

нэмэгджээ. Харин САХБ-уудын хувьд 2018 онд бусад банкуудад өгөх өглөгийн хэмжээ өөрийн хөрөнгийн 9.2 хувьтай тэнцэж байсан бол энэ үзүүлэлт 2023 онд 7.8 хувь болж буурсан байна.

Банк хоорондын өглөг, авлагын хэмжээ САХБ-уудын хувьд буурсан хэдий ч, бусад банкуудын харилцан хамаарал эрчимтэй нэмэгдэх хандлагатай байгаа нь банкны системд эрсдэл үүсгэж болзошгүй байна.

Зураг 3.16. Банк хоорондын хамаарал, (2018 оны 1 сарын байдлаар)




Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Зураас өргөн болох тусам хоорондын хамаарал өндөр байгааг илэрхийлнэ. Банк 1-5 – Системийн ач холбогдолтой банк болно. Банкны дугаар нь банкны системд эзлэх эрэмбийг илэрхийлэхгүй болно.

Иймд харилцан хамаарал өндөртэй тэдгээр банкуудад тавих хяналтыг гүнзгийрүүлэх, шаардлагатай тохиолдолд бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах боломжтой юм. Түүнчлэн, энэхүү шинжилгээг цаашид арилжааны банкууд болон бусад санхүүгийн байгууллагууд (ББСБ гэх мэт)-ыг хамарсан байдлаар шинэчлэн гүйцэтгэх нь эрсдэлийг илүү нарийвчлан тодорхойлох давуу талтай.

Зураг 3.17. Банк хоорондын хамаарал (2023 оны 6 сарын байдлаар)




ШИГТГЭЭ 5. БАНКУУДЫН ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

Монголбанкнаас “Арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г нийт 12 банкны эрсдэлийн удирдлага эрхэлсэн удирдлагуудаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулан, 2023.01.23-02.06-ны хооронд 5 дахь жилдээ зохион байгууллаа. Судалгааны үр дүнгээр арилжааны банкууд 2023 оны эрсдэлийн нөхцөл байдал, хүлээлтийг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:

- Банкуудын зээл, хадгаламж, ашигт ажиллагаа:** Банкуудын ашигт ажиллагаа нь 2023 онд өмнөх онтой харьцуулахад сайжирна гэсэн хүлээлттэй байна. Ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд 2023 онд том болон дунд банкууд дунджаар 16.7%, харин жижиг банкуудын хувьд 126%-иар зээлээ өсгөхөөр төлөвлөжээ. Ингэхдээ дээрх банкууд бүгд иргэдийн болон бизнесийн зээлийн багцуудаа аль алийг нь нэмэгдүүлэхээр тооцоолж байна. Тухайлбал, иргэдийн зээл, худалдааны салбар, жижиг дунд үйлдвэрлэлд олгох болон ногоон зээлийн багцын хэмжээг өсгөнө гэж хариулжээ. Энэ нь банкууд эдгээр сегментэд илүү ихээр төвлөрч, үйл ажиллагаагаа чиглүүлэх хандлагатай байгааг илтгэж байна. Харин хадгаламжийн хэмжээгээ өмнөх онтой харьцуулахад том банкууд дунджаар 10.3%, дунд банкууд 2.5%, жижиг банкууд 31%-иар нэмэгдүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд үйл ажиллагааны зардлаа бууруулахдаа аутсорсинг үйлчилгээ, автоматжуулалт болон цахимжуулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

- **Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн хувьд** хүлээлт өмнөх онтой харьцуулахад бага зэрэг муудсан нь төгрөгийн ханшийн сулралт банкуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж таамаглаж буйтай холбоотой юм. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийг 2023 онд өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 9%-иар суларна, үл хөдлөх хөрөнгийн үнийг дунджаар 1.7%-иар өснө гэж хүлээж байна
- **Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд** банкууд өмнөх онуудын хүлээлтийн адил мөнгөн хөрөнгийн дутагдалд орох эрсдэл бага бөгөөд хөрвөх чадвар буурахгүй гэж үзжээ.
- **Макро эдийн засгийн эрсдэл:** 2023 онд макро эдийн засагт гарах өөрчлөлтүүдийн банкны үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн хүлээлт өмнөх онтой харьцуулахад сайжирлаа. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад нэмэгдэнэ гэж таамаглаж байгаа бол жилийн инфляцыг 2023 оны эцэст 8-12% орчимд хүрч буурна гэж хүлээж байна.
- **Гадаад эрсдэлийн хувьд** 2023 оны хүлээлт 2022 оныхтой харьцуулахад бага зэрэг сайжирсан хэдий ч эрсдэл өндөр хэвээр байна. Энэ нь Ковид-19 цар тахал болон олон улсын геополитикийн зөрчлөөс шалтгаална гэж банкууд үзэв. Түүнчлэн, олон улсын геополитикийн зөрчил нь гадаад төлбөр тооцоонд хүндрэл учруулах, гадаад эх үүсвэрийн дутагдалд орох болон зээлийн эрсдэл нэмэгдэх зэргээр банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн байна.
- **Зээлийн чанарын хувьд** банкуудын 50 хувь нь бага зэрэг муудна, 42 хувь нь бага зэрэг сайжирна, 8 хувь нь өөрчлөлт гарахгүй гэсэн хүлээлттэй байв. Активын чанарыг сайжруулах хамгийн түгээмэл арга нь шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох гэж ихэнх банк үзэж байна. Тухайлбал, чанаргүй активыг шийдвэрлэхэд тулгарч буй гол бэрхшээл нь “шийдвэрлэх хугацаа хэт урт, шат дарааллын хувьд нарийн, түвэгтэй” гэж хариулсан нь 2022 оны судалгааны үр дүнтэй адил хэвээр байгаа бол дараагийн гол бэрхшээл нь “чанаргүй актив болон барьцаа хөрөнгийн худалдан авах борлуулах зах зээлийн орчин сул” гэж үзжээ.
- **Ерөнхийд нь өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулахад** 2023 онд банкны салбарын эрсдэлийн хүлээлт дийлэнх үзүүлэлтийн хувьд мууджээ. Тухайлбал, банкуудын стратеги, ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, макро эдийн засаг болон ерөнхий эрсдэлийн хүлээлт бага зэрэг муудсан үзүүлэлттэй гарлаа. Харин санхүүгийн зах зээлийн эрсдэлийн хүлээлт бага зэрэг сайжирч, гадаад эрсдэлийн хүлээлт хэвээрээ буюу дундаж эрсдэлтэй гэсэн үр дүн гарав.

Зураг 3.18. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Эрсдэлийн дундаж үнэлгээ (1-маш өндөр, 2-өндөр, 3-дундаж эрсдэлтэй, 4-бага, 5-маш бага гэсэн утгатай)

3.3 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.3.1 Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 10,998.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн бөгөөд энэ нь 2022 оны нэрлэсэн ДНБ-ий 20.8 хувьтай тэнцэж байна (Зураг 3.19). 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт арилжаалагдсан үнэт цаасны дүн өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсөж 533.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 80.5 хувийг хувьцаа, 4.6 хувийг хөрөнгө оруулалтын сан, 7.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 7.0 хувийг компанийн бонд, 7.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас тус тус эзэлж байна (Зураг 3.20).


“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас тооцдог хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилдаг ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,103.5 нэгжээр буюу 12.5 хувиар өсөж 36,899.2-д хүрэв (Зураг 3.21).

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-ын дагуу тооцоход MSE A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,831.6 нэгжээр буюу 30.9 хувиар өсөж 16,216.2 нэгж, MSE B индексийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 727.7 нэгжээр буюу 6.4 хувиар өсөж, 12,178.6 нэгжид тус тус хүрээд байна. (Зураг 3.21).

Банкууд IPO хийсэн нь хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүллээ.


Системийн нөлөө бүхий банкууд IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор хөрөнгийн зах зээлд хөрвөх чадвар өндөр санхүүгийн шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүллээ.

Зураг 3.19. Зах зээлийн үнэлгээ, эхний хагас жилийн эцсийн байдлаар /их наяд төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.20. Үнэт цаасны арилжаа, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.21. MSE A, MSE B, ТОП-20 индекс, эхний хагас жилийн байдлаар /хаалтын ханш, сараар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банкуудын IPO хийх ажиллагаа амжилттай болж дотоодын зах зээлийн үнэлгээ 5.7 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 2023 оны 6 дугаар сарын эцэст нийт зах зээлийн үнэлгээ 10.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд цаашид 11 их наяд төгрөгийг давах хүлээлттэй байна.

Банкны салбарын реформоос гадна ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах зэрэг томоохон арга хэмжээнүүдийн үр дүнд хөрөнгийн зах зээлийн цар хүрээ тэлэх хүлээлттэй байна.


Дэлхийн зах зээлд тодорхой бус байдал өндөр байна. Орос-Украины нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээр өндөр хэлбэлзэлтэй байгаа түүхий эдийн үнэ, хүнс, эрчим хүчний үнийн огцом өсөлт, улс орнуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж олон улсын хэмжээнд тодорхой бус байдал үүслээ. Уг үүсээд буй тодорхой бус байдлаас шалтгаалан хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнууд руу хөрөнгө гадагшлах, үнэт цаасны арилжааны хэмжээ, зах зээлийн үнэлгээ буурах зэргээр хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг бууруулах эрсдэлтэй.

3.3.2 Даатгалын салбар

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 518.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар өссөн бол нөөц сангийн хэмжээ 244.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар нэмэгдээд байна (Зураг 3.22).

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 53.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин давхар даатгалын нөхөн төлбөр 2.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны үеэс 54.1 хувиар буурлаа (Зураг 3.23).

Зураг 3.22. Даатгалын салбарын нийт хөрөнгө, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.23. Даатгалын нөхөн төлбөр, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.24. Даатгалын хураамж, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 169.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлсний 98.8 хувь буюу 167.1 тэрбум төгрөгийг ердийн даатгалын

компаниуд, 1.2 хувь буюу 2.1 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компаниуд тус тус төвлөрүүлсэн бөгөөд даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 36.1 хувиар өсөв (Зураг 3.24).

Даатгалын зах зээлийн бүтэц

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 18 даатгалын компани, 64 даатгалын үнэлэгч, 25 даатгалын хохирол үнэлэгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна (Хүснэгт 3.1)

Хүснэгт 3.1. Даатгалын зах зээлийн оролцогчид


№	Даатгалын зах зээлийн оролцогчид	2023.II
1	Даатгалын компанийн тоо	18
	Үүнээс: ердийн даатгалын компани	15
	Үүнээс: урт хугацааны даатгалын компани	2
	Үүнээс: давхар даатгалын компани	1
2	Даатгалын зуучлагч компанийн тоо	64
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн тоо	25
4	Аудитын компанийн тоо	44
5	Аудиторын тоо	145
6	Актуарчийн тоо	40
7	Даатгалын төлөөлөгчийн тоо	2381

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3.3 Банк бус санхүүгийн байгууллагын салбар

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 522 банк бус санхүүгийн байгууллага/ББСБ/үйлажиллагаа эрхэлж байгаагаас 81.8 хувь нь Улаанбаатар хотод байршдаг. Нийт ББСБ-уудын 92.1 хувь буюу 481 нь тусгай зөвшөөрлийн дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэж байна. Харин салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 3.9 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар, зээлдэгчийн тоо 1.3 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар тус тус буураад байна (Зураг 3.25).

Зураг 3.25. ББСБ-ын харилцагчид (мянга) ба тоо, эхний хагас жилийн эцсийн байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тодруулбал, нийт хөрөнгө 2023 оны 2 дугаар улирлын эцэст 3.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар, нийт зээлийн хэмжээ 3.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар тус тус өслөө (Зураг 3.26). Түүнчлэн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын орлогын хэмжээ 32.7 хувиар буюу 128.2 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 36.4 хувиар буюу 88.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 26.8 хувиар буюу 26.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 3.26. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын нийт зээлийн 89.0 хувийг буюу 2.8 их наяд төгрөгийг хэвийн, 3.3 хувийг буюу 103.1 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн,


7.7 хувийг буюу 237.4 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө (Зураг 3.27).

ББСБ-уудын эх үүсвэр татан төвлөрүүлэх сувгууд нэмэгдэж байна. ББСБ нь банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон өрийн бичиг гаргах замаар иргэн, хуулийн этгээд, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөлхөтөлбөрөөс зээл хэлбэрээр тус тус эх үүсвэр татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой байдаг. 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг, ББСБ-аас гаргасан өрийн бичиг, төслийн зээлийн санхүүжилт зэрэг бусдаас татсан эх үүсвэр нь нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн нийлбэрийн 29.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм (Зураг 3.28).

Түүнчлэн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 49.6 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 8.4 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн өглөг 21.0 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 60.7 хувиар тус тус өсөв.


ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээ, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага болон өрийн бичиг, төслийн зээлийн санхүүжилтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байна. Иймд компанийн засаглалын кодексыг баримтлаагүйгээс буруу шийдвэр гаргах, харилцагчийг таних үйл ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлээгүйгээс зээл эргэн төлөгдөхгүй байх, цаашлаад бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг эргэн төлөх чадваргүй болох эрсдэлтэй.

Зураг 3.27. ББСБ-ын зээлийн чанар, эхний хагас жилийн эцсийн байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.28. ББСБ-ын бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүнд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


3.3.4 Хадгаламж, зээлийн хоршооны салбар

2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоо/ХЗХ/-дын тоо өмнөх онтой харьцуулахад 4.0 хувиар буурч 192-д хүрлээ. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурч 71,184 гишүүн болжээ. Тайлант улиралд нийт 192 ХЗХ-ноос 101 ХЗХ нь Улаанбаатар хотод, 91 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна. Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 7.3 сая төгрөгийн зээлтэй байна. Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн

12.0 сая төгрөг байгаа бол орон нутагт 3.1 сая төгрөг байна.


2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өсөж 295.9 тэрбум төгрөгт, нийт зээлийн хэмжээ 1.2 хувиар өсөж 220.4 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Түүнчлэн, цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өсөж 215.7 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 17 хувиар буурч 4.7 тэрбум төгрөгт хүрэв (Зураг 3.29-3.30).

Зураг 3.29. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө ба хөрөнгийн өсөлт, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.30. ХЗХ-дын нийт зээл ба чанаргүй зээл, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт зээлийн үлдэгдлийн 93.1 хувь буюу 205.1 тэрбум төгрөгийг хэвийн, 3.6 хувь буюу 8.0 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.3 хувь буюу 7.3 тэрбум төгрөгийг чанаргүй

зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өсөж 26.4 хувь, эргэлзээтэй зээлийн эзлэх хувь 16.7 нэгж хувиар өсөж 34.4 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх жин 39.2 хувь байна (Зураг 3.31).

Зураг 3.31. Чанаргүй зээлийн ангилал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өсөж 203.9 тэрбум төгрөг боллоо (Зураг 3.32).

Зураг 3.32. ХЗХ-дын хадгаламж, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү 1.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар тус тус өслөө (Зураг 3.33).

Зураг 3.33. Хадгаламж болон зээлийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт олгосон зээлийн 46.5 хувь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 18.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 15.8 хувь нь машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар олгогдсон. Нийт эргэн төлөгдсөн зээлийн 48.7 хувь хэрэглээ болон түүнд холбогдох бусад зориулалтаар, 18.2 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаанаас, 16.5 хувь нь машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар олгосон зээл бүрдэж байна.

ХЗХ-ны салбарын хөрөнгийн төвлөрөл өндөр байна. Салбарын хэмжээнд том 20 ХЗХ-ны хөрөнгө нийт салбарын хөрөнгийн 81.2 хувийг бүрдүүлдэг бөгөөд үүний дотор том 4 ХЗХ-ны хөрөнгө нийт салбарын хөрөнгийн 56.7 хувийг бүрдүүлж байна. Эдгээр том 20 ХЗХ, үүний дотор том 4 ХЗХ нь санхүүгийн гол үзүүлэлтүүдийн 70-80 орчим хувийг дангаараа бүрдүүлж байгаа нь ХЗХ-ны салбарт төвлөрөл, түүнээс үүдэх эрсдэл өндөр байгааг харуулж байна.

ХЗХ-дын өмнөх түүхээс үүдэн иргэдийн ХЗХ-нд итгэх итгэл сул бөгөөд одоогийн мөрдөгдөж буй ХЗХ-ны тухай хуулинд гишүүдийн хадгаламж даатгагдсан байх талаар зохицуулалтыг тусгасан боловч хэрэгжих эрх зүйн орчин бүрдээгүй байна.

3.3.5 Виртуал хөрөнгийн зах зээл

Монгол улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын хувьд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд нийт 12 хуулийн этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэлтэй байна.


Эдгээр 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн платформ дээр давхардсан тоогоор нийт 912,238 хэрэглэгч бүртгэлтэй. Үүнээс 50.2 хувь буюу 458,205 хэрэглэгч бүртгэлээ баталгаажуулсан бол 9.3 хувь буюу 85,312 хэрэглэгч идэвхтэй арилжаанд оролцдог (Зураг 3.34). Түүнчлэн, 211 виртуал хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 19 хувь буюу 41 нь дотоодын харин үлдсэн 81 хувь буюу 170 нь гадаадын виртуал хөрөнгө болно (Зураг 3.35).

Зураг 3.34. ВХҮҮ-ийн харилцагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.35. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн төрөл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хийгдсэн өдрийн дундаж арилжаа 128.0 сая төгрөг байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн 98.2 тэрбум төгрөг, зах зээлийн үнэлгээ 263.9 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Виртуал хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд бүртгэгдснээр нийт хөрөнгийн хэмжээ 50.6 тэрбум төгрөг, орлогын хэмжээ 2.8 тэрбум төгрөг, тайлант үеийн алдагдал 7.01 тэрбум төгрөг байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон бусад төрийн байгууллагууд хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн дагуу СЗХ нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 10 харилцааг зохицуулсан 8 журмыг батлаад байна.

Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан аливаа төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл (inherent risk) өндөр байна. Виртуал

хөрөнгийн салбарт үүсэж болох олон төрлийн эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг бууруулах зорилгоор зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловч тухайн салбараар дамжуулан үйлдэх аливаа төрлийн гэмт хэргийн эрсдэл өндөр байна. Тухайлбал, мэдээллийн аюулгүй байдал буюу харилцагчдын хувийн мэдээлэл, арилжааны системийн аюулгүй байдлыг алдах эрсдэл өндөр байна. Түүнчлэн, виртуал хөрөнгийн үйлчилгээний онцлог талыг ашиглан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж болзошгүй юм.


Дэлхийн зах зээлд криптовалютын хэрэглээ нэмэгдэж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дэлхийн зах зээлд нийт 798 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 10,024 төрлийн виртуал хөрөнгө арилжаалж байгаа бөгөөд өдрийн арилжааны дундаж хэмжээ 28.1 орчим тэрбум доллар байна. 2023 онд олон улсын зах зээлд өмнөх онтой харьцуулахад криптовалютын хэрэглээ нэмэгдэж, салбарын өсөлт тэллээ. Түүнчлэн, криптовалютад хөрөнгө оруулах хүмүүсийн тоо болон криптовалютыг төлбөрийн хэрэгсэл хэлбэрээр ашиглах компаниудын тоо нэмэгдэх төлөвтэй байна.

3.4 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.4.1 ББСБ-ын хэрэглээний зээлийн өсөлт, түүнээс үүдсэн эрсдэл, эмзэг байдал

ББСБ-ын олгох иргэдийн хэрэглээний зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдэж байна. Тодруулбал, 2023 оны II улирлын эцсийн байдлаар ББСБ-ын хэрэглээний зээлийн үлдэгдэл 1.6 их наяд төгрөгт хүрч, 2018 оны эцсээс 4.3 дахин нэмэгджээ (Зураг 3.36). Үүнд нийлүүлэлт талаас ББСБ-уудын санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн нь нөлөөлөхийн зэрэгцээ технологийн дэвшилээр Финтекийн салбарын үйл ажиллагаа эрчимжсэн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн, зээлийн эрэлт талаас банкнаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны хязгаарлалт тогтоосон нь нөлөөлсөн байх талтай.

Зураг 3.36. ББСБ-ын хэрэглээний зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүжилтийн эх үүсвэр тэлэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсөхийн зэрэгцээ өр төлбөрийн хэмжээ ихээхэн нэмэгдсэн нь нөлөөлөв. Тодруулбал, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2018-2021 оны хооронд авч хэрэгжүүлсэн ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээний нөлөөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2018 оноос 1.9 дахин өссөн байна. Үүнээс гадна ББСБ-уудын

өр төлбөрийн хэмжээ 2019-2022 онд огцом нэмэгдсэн нь ББСБ-уудын зээл хурдацтай өсөх шалтгаан болов. Тодруулбал, ББСБ-уудын өр, төлбөрийн хэмжээ 2018 онтой харьцуулахад 4.8 дахин нэмэгдсэн байна. ББСБ-уудын гадаад, дотоод банк санхүүгийн байгууллагад өгөх өглөг, итгэлцлийн үйлчилгээний өглөг, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн дүн өндөр өсөлттэй байсан нь нийт өр, төлбөрийн дүн ийнхүү огцом өсөх шалтгаан болов (Зураг 3.37).

Зураг 3.37. ББСБ-ын өр төлбөрийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банкуудаас олгох хэрэглээний зээлд хязгаарлалт тавьснаар зээлийн эрэлт ББСБ-руу шилжсэн байх магадлалтай байна. Банкуудаас иргэдэд олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалт тогтоосноос хойш банкны хэрэглээний зээлийн өсөлт тогтворжиж 2023 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 2018 оны эцэстэй харьцуулахад 22.1 хувиар өсжээ. Энэ хугацаанд ББСБ-ын хэрэглээний зээл 4.3 дахин тэлсэн нь ӨОХ-ны хязгаарлалтад тулсан, банкнаас зээл авах боломжгүй иргэдийн зээлийн эрэлт тус хязгаарлалтгүй хэсэгт шилжсэн байх магадлалтайг харуулж байна.

СЗХ-ны шийдвэрээр 2023 оноос эхлэн финтек зээлүүдэд өр, орлогын болон хугацааны хязгаарлалтыг мөрдүүлж эхэлсэн боловч хязгаарлалт тогтоогоогүй хэрэглээний зээлийн өсөлт өндөр байна.


Тухайлбал, 2023 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-уудын хэрэглээний зээлийн үлдэгдлийн 31.4 хувийг буюу 515.2 тэрбум төгрөгийг финтек зээлүүд бүрдүүлж байгаа бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн энэ төрлийн зээлүүдэд өр, орлогын харьцааны хязгаарлалт 70 хувиар тогтоохоор шийдвэрлэсэн (Зураг 3.38). Гэсэн хэдий ч, 2022 онд нийт хэрэглээний зээлийн өсөлтийн дийлэнх хувийг хязгаарлалтгүй хэсэг болох уламжлалт зээлийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг 3.39). Иймд тус хязгаарлалтын арга хэмжээг бүх төрлийн хэрэглээний зээлд давхар мөрдүүлэх нь санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтуудын харилцан уялдааг сайжруулж, санхүүгийн системд эрсдэл нэг салбараас нөгөө салбарт шилжин бодлогын үр нөлөөг сулруулахгүй байх боломжтой.

Зураг 3.38. ББСБ-ын хэрэглээний зээлд эзлэх финтек зээлийн хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.39. ББСБ-ын хэрэглээний зээлийн жилийн өсөлтийн хувь, бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.4.2 Банк болон ББСБ-д давхар зээлтэй иргэдийн зээлд хийсэн шинжилгээ

Банк болон ББСБ-аас 277 мянган иргэн давхар зээлтэй байна. Зээлийн мэдээллийн сангийн 2023 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаарх тоон мэдээлэлд үндэслэн банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн мэдээллийг шинжлэхэд тэдгээр иргэдийн нийт зээлийн үлдэгдэл 6 их наяд төгрөг, үүнээс банканд хамаарах нь 4.7 их наяд төгрөг байна (Зураг 3.40). Энэ нь банкны иргэдийн зээлийн үлдэгдлийн 38 хувь, ББСБ-ын хувьд 52 хувийг бүрдүүлэв. Нэг иргэн дунджаар 4 зээлтэй, зээлийн үлдэгдэл нь 21.7 сая төгрөг байна.

Зураг 3.40. Банк болон ББСБ-аас олгосон иргэдийн зээлийн үлдэгдэл, их наяд төгрөг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Давхар зээлтэй иргэд банкнаас урт хугацаагаар их хэмжээний, ББСБ-аас богино хугацаагаар, бага хэмжээний зээлүүд авдаг байна. Тухайлбал, тэдгээр иргэдийн банкны зээлийн дундаж хугацаа 38 сар, ББСБ-ын хувьд 17 сарын хугацаатай зээл авчээ. Түүнчлэн, ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 34 хувь нь 5 сая төгрөгөөс доош үлдэгдэлтэй зээлүүд байна.

Банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн дундаж ӨОХ ойролцоолсон тооцооллоор 80.3 хувьтай байгаа нь **эдгээр иргэдийн хувьд бодит өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна.** Банкны хэрэглээний зээлийн дундаж ӨОХ-ны үзүүлэлтэд ББСБ-ын зээлийн үлдэгдлийг³ нэмж тооцвол зээлдэгчийн ӨОХ дунджаар 20.3 нэгж хувиар нэмэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл давхар зээлтэй иргэд сарын орлогынхоо дунджаар 80.3 хувийг зээлийн төлбөртөө төлж байгааг илэрхийлнэ.

³ Иргэн тус бүрийн хувьд банкнаас авсан хамгийн сүүлийн зээлээс хойш ББСБ-аас авсан зээл

4. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

4.1 БАНКНЫ САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

4.1.1 Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн арга хэмжээнүүд

Монголбанк банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлүүлэн хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн томоохон зорилтуудын нэг болох банкны хяналт, шалгалтын стандартыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Системд нөлөө бүхий банкуудад Активын чанарын үнэлгээг гүйцэтгэв. Банкны салбарын реформын хүрээнд системд нөлөө бүхий банкууд олон нийтэд хувьцаагаа гарган компанийн хэлбэрээ өөрчлөхөөс өмнө Монголбанкны санаачилгаар банкуудын актив хөрөнгийн чанар, эрсдэлийн сан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтоох, гадаад, дотоодын оролцогч талуудыг бодит мэдээллээр хангах зорилгоор Активын чанарын хараат бус, хөндлөнгийн үнэлгээг олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар үнэлүүллээ.

Системд нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн багцын 70 орчим хувийг үнэлгээнд хамруулж, тэдгээрт харгалзах 300 барьцаа хөрөнгийн үнэлгээнд баталгаажуулалт хийсэн бөгөөд үр дүнг банкуудын тайланд тусгуулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих болон Банкны тухай хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

“Банкыг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн батлав. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А-226 дугаар тушаалаар “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. Уг журмын дагуу банкууд 2021 оны 4 дүгээр сарын 15-ны дотор тогтворжуулах төлөвлөгөөг Монголбанканд ирүүлсэн. Тогтворжуулах төлөвлөгөө нь системийн хэмжээнд болон тухайн банканд үүсэж болзошгүй хүндрэлтэй нөхцлийн үед өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, ашигт ажиллагаа, актив чанарыг хадгалах арга хэмжээг урьдчилан тодорхойлж, хямралыг аль болох богино хугацаанд хохирол багатай даван туулах, бэлэн байх нөхцлийг бүрдүүлэх зорилготой.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А-25 дугаар тушаалаар “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын дагуу Тогтворжуулах төлөвлөгөөг банкууд жил бүрийн 4 сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

“Банкыг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн авагч томилох, дуусгавар болгох журам”-ыг шинэчлэн батлав. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А-15 дугаар тушаалаар “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх, банкны эрх хүлээн

авагч томилох, дуусгавар болгох журам”-ыг шинэчлэн батлав. Уг журам батлагдсанаар банкны эрх хүлээн авагч (БЭХА)-ийн зарим төрлийн үйл ажиллагаа тодорхой болж, банкныг татан буулгах арга хэмжээний хэрэгжилт илүү үр дүнтэй болох ач холбогдолтой юм. Тухайлбал, БЭХА-ийн ажиллах дээд хугацаа, ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, банкны хөрөнгө худалдан борлуулах бүрэн эрх, нэхэмжлэлийн шаардлагыг төгрөгөөр баталгаажуулах зэрэг онцлог зохицуулалтууд тусгагдсан. Нөгөө талаас, Монголбанк банкныг албадан татан буулгах үндэслэл, шийдвэр гаргах процессийг нарийвчлан тусгав.

“Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүү бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батлав. “Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” шинэчлэн батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “Хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.”, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт “Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.” гэж тус тус заасантай холбогдуулан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүү бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулан аргачлалын төслийг боловсруулав. Улмаар аргачлалыг Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны

даргын хамтарсан 2023 оны 5 дугаар сарын 23-ний өдрийн А-106/298 дугаар тушаалаар баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн болно.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банктай холбоотой журам, тушаалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батлав. Хөрөнгө оруулалтын чиглэлээр банкны салбарт үйл ажиллагаа явуулах төрөлжсөн банкны эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор дараах нэр бүхий 3 журам, 1 тушаалыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А-164/386, А-165/385 дугаартай тушаалаар тус тус батлагдсан. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг тогтоох тухай Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаал.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн хүрээнд дээрх журам, тушаалууд батлагдсанаар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл олгох, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хязгаарлалт, зохистой харьцаа, хяналт шалгалттай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.


4.1.2 Макро зохистой бодлогын арга ХЭМЖЭЭНҮҮД

Монголбанк нь санхүүгийн системийн мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор 2019 оноос эхлэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.

**Банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд
өр орлогын харьцааны болон хугацааны
хязгаарлалт тогтоох макро зохистой
бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна.**


Монголбанкнаас иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах, өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ) болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн билээ. Тус арга хэмжээний үр нөлөөгөөр банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2019 оноос хойш харьцангуй тогтворжиж, шинээр олгосон хэрэглээний зээлийн хугацаа богино болсон ба хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцаа буурч хязгаарлалтаас доогуур түвшинд хадгалагдаж байна (Зураг 4.1, 4.2). Тодруулбал, 2018 оны эцэст 36.2 хувьд хүрээд байсан банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ 2019 оноос эхлэн буурч, 2021-2022 онд дунджаар 26.6 хувьд хүрч тогтворжсон (Зураг 4.3). Түүнчлэн, 2023 оны 7 дугаар сарын байдлаар нийт хэрэглээний зээлийн үлдэгдлийн дундаж ӨОХ нь 50.1 хувь, дундаж хугацаа нь 28.6 сар байна.

Зураг 4.1. Шинээр олгосон зээлийн жилийн өсөлт /бүрэлдэхүүнээр/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4.2. Банкуудаас иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа, ӨОХ




Эх сурвалж: Монголбанк

Өр орлогын харьцааны хязгаарлалтаас гадуурх хэрэглээний зээлийн өсөлт эрчимжив. 2020 оны 12 дугаар сараас макро зохистой бодлогын өр, орлогын харьцаа, хугацааны хязгаарлалт тэтгэврийн зээлийн хувьд хэрэгжихгүй болж, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд тусгагдсан байсан хугацааны хязгаарлалт 2021 оны 7 дугаар сард уг хуулийн шинэчилсэн найруулгаас хасагдсанаас хойш тэтгэврийн зээлийн хэмжээ огцом нэмэгдэж эхэлсэн¹. Түүнчлэн, цар тахлын үед төрөөс

¹ Хязгаарлалт бүхий бусад хэрэглээний зээлд цалингийн, малчны, автомашины, картын, өрхийн хэрэглээний болон бусад хэрэглээний зээлүүд хамаарна. Тэтгэврийн зээл 2019 болон 2020 онуудад ӨОХ-ны хязгаарлалттай байсан.

үзүүлсэн бодлогын нөлөөгөөр иргэдийн хадгаламж өсөж, улмаар 2022 оны дунд үеэс хадгаламж барьцаалсан зээлийн хэмжээ ихээр нэмэгдэв. Нөгөөтэйгүүр, 2023 он гарсаар цалин, тэтгэврийн хэмжээ өсснөөс шалтгаалан ӨОХ-ны хязгаарлалт бүхий хэрэглээний зээлийн өсөлт нэмэгдэв. Улмаар 2023 оны 7 дугаар сарын байдлаар банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ 30.3 хувьд хүрч өслөө.

Зураг 4.3. Банкны салбарын нийт зээлд хэрэглээний зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү арга хэмжээг дан ганц банкны салбарт хэрэгжүүлэх нь хэрэглээний зээлийн эрэлт Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) руу шилжиж, бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэл учруулж байна. Тодруулбал, 2023 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ББСБ-ын нийт хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар буюу 208.7 тэрбум төгрөгөөр өсөж 1.6 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь банкнаас олгох хэрэглээний

зээлд ӨОХ болон хугацааны хязгаарлалт тогтоохоос өмнөх үе буюу 2018 оны эцсээс 4.3 дахин нэмэгдсэн дүн юм. Иймд банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд тавигдаж буй дээрх хязгаарлалтын арга хэмжээг банкны бус санхүүгийн салбарт давхар мөрдүүлэх нь өрхийн өрийн дарамтыг бодитоор бууруулах, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна (Бүлэг 3.4).


Банкуудын гадаад зах зээлээс шинээр татсан зарим эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох тухай шийдвэр гаргав. Тодруулбал, эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2022 оны 3 дугаар улирлын ээлжит хурлаар банкуудын гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр 360 хоног болон түүнээс дээш хугацаагаар шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөх шийдвэрийг гаргасан. Түүнчлэн, МБХ-ны 2023 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар нэмж банкуудын гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр 360 хоног хүртэлх хугацаатай шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөхөөр шийдвэрлэлээ.

Энэ арга хэмжээ нь хөрөнгийн орох урсгалын төлөв хангалтгүй үед банкуудад гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгож, улмаар хөрөнгийн орох урсгал, гадаад тэнцвэрт эерэг нөлөө үзүүлэх юм.

ШИГТГЭЭ 6. САНХҮҮГИЙН МӨЧЛӨГ

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл 2021 оны сүүл үеэс сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарч, хөнгөлөлттэй хөтөлбөрүүдийн зээл олголт нэмэгдсэнээр манай улсын санхүүгийн мөчлөг сэргэж эхэлсэн бөгөөд энэхүү сэргэлт 2023 оны 2 дугаар улирлын байдлаар үргэлжилсэн хэвээр байна (Зураг 4.4). Ийнхүү зээл олголт сэргэсэн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлэх эерэг нөлөөтэй боловч нийт нийлүүлэлтийн тэлэх боломж хязгаарлагдмал үед зээл хэт ихээр нэмэгдвэл санхүүгийн системд мөчлөгийн эрсдэл хуримтлагдана. Цаашид зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулан тогтвортой хадгалах шаардлагатай юм.

Зураг 4.4. Бизнесийн болон санхүүгийн мөчлөг²



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: *Зээлийн бодит өсөлт, **зээл ба ДНБ-ий харьцаа.

Өмнөх жилүүдэд тохиож байсан бодит эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн уналтууд давхцаж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэн, банк, санхүү, бодит эдийн засгийн хүндрэл үүсэх эрсдэл арилаагүй хэвээр байна. Тухайлбал, Орос-Украины хурцадмал байдал, үүнээс үүдэлтэй худалдааны хориг арга хэмжээнүүд нь дэлхийн эрчим хүч, хүнс болон түүхий эдийн зах зээлд сөрөг шокууд бий болгон, улмаар дэлхийн улс орнуудад инфляцын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилийг сааруулах зэргээр макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэв. Цаашид энэхүү нөхцөл байдал даамжирсан тохиолдолд дэлхийн улс орнуудад эрчим хүч, хүнсний нийлүүлэлтийн хомсдол, инфляцын өндөр түвшин илүү урт хугацаанд хадгалагдах, эдийн засгийн хүндрэл үүсгэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Түүнчлэн, АНУ, Евро бүс зэрэг хөгжингүй орнуудын засгийн газрууд, компаниуд болон өрхүүд зах зээл дээрх хүүгийн өсөлт болон зардлын өсөлттэй нүүр тулж байна. Өрийн дарамт өндөр байгаа засгийн газрууд, аж ахуйн нэгж, этгээдийн хувьд өрийн тогтвортой байдлаа хангах нь маш том сорилт болж, цаашид глобал санхүүгийн хямралд хүргэж болзошгүй юм. 2023 оны эхээр АНУ, Европын томоохон банкууд хүндрэлд орж, дампуурлаа зарласан нь нөхцөл байдал ноцтой муудах эрсдэлтэйг харуулав.

² Санхүүгийн мөчлөгийг “Зах зээлийн эрсдэл, үнэ цэнийг хүлээж авах байдал болон санхүүгийн хязгаарлалтын бие биеийгээ өдөөсөн харилцан хамаарал буюу хөөсрөлт уналтын харилцан солбисон үйл явц” хэмээн тодорхойлох нь түгээмэл байдаг. Монгол Улсын санхүүгийн мөчлөгийг тооцохдоо хөрөнгийн үнэ цэнийг орон сууцны үнийн өсөлтөөр, зээлийн хязгаарлалтыг бодит зээлийн өсөлт болон зээл, ДНБ-ий харьцаагаар тус тус төлөөлдүүлэв.

4.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, виртуал хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.2.1 Хөрөнгийн зах зээл

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцэслэн боловсруулж, 2023 оны УИХ-ын намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.
- Банкны салбарын реформын хүрээнд СЗХ-ны зүгээс зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагаанд зөвлөгөө мэдээлэл өгч дэмжин ажиллав.
- ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор СЗХ МҮХАҮТ-тай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг батлав.
- УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн хүрээнд төрийн өмчит хувьцаат компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах ажиллагаанд оролцож, хамтран ажиллаж байна.

- Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хэрэгжилтэд СЗХ хяналт тавихаар зохицуулсны дагуу СЗХ-ноос “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам”-ыг бусад байгууллагуудтай хамтран баталж, экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд хяналт тавин ажиллаж байна.
- “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ийг Зөвшөөрлийн тухай хууль болон зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэх үүднээс шинэчлэв.

4.2.2 Даатгалын салбар

- СЗХ-ноос хөрөнгийн зах зээлийг дэмжих, нөгөөтэйгүүр даатгагчийн хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлтийг оруулав.
- УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор СЗХ-ноос “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг 2023 оны 46 дугаар тогтоолоор баталсан.
- Даатгалын багц хуулийн төсөлд заавал даатгалын хэрэгжилтийг сайжруулах зохицуулалтыг тусгахаас гадна салбарын төрийн захиргааны төв байгууллагуудтай холбогдох даатгалын чиглэлээр хамтран ажиллаж байна.

4.2.3 Банк бус санхүүгийн салбар

- ББСБ-уудын нягтлан бодох бүртгэлийн тайлагналыг санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нийцүүлэх хүрээнд “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж, төслийг Сангийн Яаманд хүргүүлээд байна.
- ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах хүрээнд СЗХ-ноос “Итгэлцийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарь”-ийг 2023 оны 136 дугаар тогтоолоор батлав.
- ББСБ-уудын мөнгө угаах, мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг дамжуулан ашиглах эрсдэлийг бууруулах хүрээнд СЗХ-ноос “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2023 оны 220 дугаар тогтоолоор баталсан.

4.2.4 Хадгаламж зээлийн хоршоо

- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

- АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй ТА 9654-MON “Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл болгон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан.

4.2.5 Виртуал хөрөнгийн зах зээл

- СЗХ-ноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)-ийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-аас ВХҮҮ-ийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь ВХҮҮ-ийн 10 харилцааг зохицуулсан 8 журмыг батлав.
- ВХҮҮ-ийн хэрэглэгчдийн тоо, ханш, арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг өдөр бүр API системээр хүлээн авч, хяналт тавин ажиллаж байна.
- Виртуал хөрөнгийн хяналтын систем болох “Chainalysis” программыг хяналт, зохицуулалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна.